МАНАЙ СОНИНЫ II УЛИРЛЫН НЭМЭЛТ ЗАХИАЛГА ЯВАГДАЖ БАЙНА

MMINFO.

19 дэх жилдээ

# МОНГОЛЫН МЭДЭЭ

Хүн ам 3,139.707... ҮСХ-ны өчигдрийн мэдээгээр

2017.04.27. Пүрэв. №083 (4697) ӨДӨР ТУТМЫН АНХНЫ ЧӨЛӨӨТ ХЭВЛЭЛ Худалдах үнэ 500 төг

# ИРГЭДИЙН МЭДЭХ ЭРХЭНД ОНЦ АЮУЛ УЧИРЛАА

**ХААН банк**

| | Авах | Зарах | | Авах | Зарах |
|---|---|---|---|---|---|
| АМ.ДОЛЛАР | 2415.00 | 2429.00 | ФУНТ | 3062.00 | 3156.00 |
| ЕВРО | 2613.00 | 2680.00 | РУБЛЬ | 42.20 | 44.30 |
| ИЕН | 21.63 | 21.96 | ЮАНЬ | 349.50 | 352.70 |

**Худалдаа хөгжлийн банк**

| | Авах | Зарах | | Авах | Зарах |
|---|---|---|---|---|---|
| АМ.ДОЛЛАР | 2416.00 | 2428.00 | ФУНТ | 3069.00 | 3143.00 |
| ЕВРО | 2614.00 | 2679.00 | РУБЛЬ | 41.91 | 45.07 |
| ИЕН | 21.46 | 22.03 | ЮАНЬ | 350.00 | 352.90 |

*Өчигдрийн 19.00 цагийн байдлаар*

E-mail: mongoliin_medee@yahoo.com

Реклам, зар сурталчилгааны алба: **99173710**

ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

# ШАХААНЫ “ЭРДЭНЭТ”-ИЙГ ШИЛ, ТОЛЬ ШИГ ТУНГАЛАГ АРИУН БАЙЛГАНА ГЭВ

–Уул уурхайн салбарын төвийн бүсийн чуулган Орхон аймагт болно–

Б.ТОГТОХ

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Нандинжаргал, Уул уурхайн бодлогын газрын дарга Ж.Ганбаатар, “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн захирал Х.Бадамсүрэн, АМГТГ-ын дарга Б.Баатарцогт нар өчигдөр сэтгүүлчдэд мэдээлэл хийлээ. Тодруулбал, уул уурхайн салбарын хөгжлийн чиг хандлага, хөрөнгө оруулалтыг татах зорилгоор бүсчилсэн чуулган зохион байгуулах болон ашигт малтмал, газрын тосны газрын энэ сарын дүн мэдээг танилцуулсан юм. Өнөө жилийн хувьд Монголд уул уурхайн салбар үүсч хөгжсөний 95 жилийн ой болж байгаа бөгөөд энэ хүрээнд уул уурхайн салбарын өнөөгийн байдал, хөгжлийн чиг хандлага, хөрөнгө оруулалтын үр өгөөж, орон нутгийн хамтын ажиллагаа, байгаль орчны нөхөн сэргээлт, бичил уурхайн зохицуулалт зэрэг олон асуудлыг хөндсөн чуулганыг бүсчлэн зохион байгуулахаар болжээ. Тус яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Нандинжаргал хэлэхдээ “2016 оны эцсийн байдлаар дотоодын нийт бүтээгдэхүүний 18 хувь, экспортын 86 хувь, аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний 71 хувь, Улсын нэгдсэн төсвийн орлогын дөрөвний нэг хувийг тус тус бүрдүүлж буй уул уурхайн салбартай эдүгээ 40 мянга гаруй хүн ажил, амьдралаа холбон хөдөлмөрлөж байна. Улс орны эдийн засаг хямралтай үед төдийгүй хэвийн үед ч ачааны хүндийг үүрч ирсэн энэ салбарын үр өгөөжийг бодитой ойлгож, зөв мэдээлж, байгалийн баялагийг зүй зохистой ашиглах замаар нийгэм, эдийн засгийн бусад салбараа өөд татахыг нийтээрээ анхаарах цаг болсныг салбарынхан уриалж байна. Тиймээс салбарын 95 жилийн ойн хүрээнд Уурхайчдын өдрийг угтах, тэмдэглэн өнгөрүүлэх ажлыг зохион байгуулах ажпын хэсэг энэ чиглэлд хийх жилийн ажлын төлөвлөгөөгөө баталж, салбараа нийтэд таниулах ажпаа эхлүүллээ” хэмээн ярив. Бүсчилсэн чуулганы эхнийх нь ирэх тавдугаар сарын 4-нд Орхон аймагт болох бөгөөд Дархан-Уул, Эрдэнэт, Өвөрхангай, Булган, Хөвсгөл зэрэг төвийн бүсийн найман аймгийн уул уурхайн салбарынхан зөвлөлдөх аж. Чуулганы үйл ажиллагаанд Монгол Улсын Ерөнхий сайд, Улсын их хурлын гишүүд, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны сайд, Орон нутгийн удирдлагууд, эрдэмтэн судлаачид болон Уул уурхайн салбарын аж ахуйн нэгж, байгууллагын төлөөлөгч нар оролцоно гэдгийг дуулгалаа. Цаашлаад хангай, баруун, говийн бүсийн чуулганыг 9, 10, 11 дүгээр сард тус тус зохион байгуулахаар шийдвэр гарсан байна. Мэдээллийн дараа сэтгүүлчид сошиал ертөнц болон хэвлэл мэдээллээр гараад буй Эрдэнэт үйлдвэрийн захирал Х.Бадамсүрэнгийн 180 сая төгрөгөөр байр авсан, 300 сая төгрөгийн машин унаж, улмаар өөрийн хуучин машинаа Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт шилжүүлсэн асуудлаар Х.Бадамсүрэн даргаас тодрууллаа.



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

## Х.Бадамсүрэн: Би гурван сая төгрөгийн цалин авдаг

...“Эрдэнэт үйлдвэр”–ийн ерөнхий захирал, орлогч нарт өмнө нь шинээр байр бариад өгсөн тохиолдол байсан. Бэлэн байрнаас ч худалдаж аваад өгчихдөг юм байна лээ. Тэр жишгээр явсан асуудал. Энд Х.Бадамсүрэн гэдэг хүн очоод тансагласан зүйл байхгүй. “Эрдэнэт үйлдвэр” хэмнэлтийн бодлогоо барьж ажиллаж байгаа...

**-Та амьдардаг байраа 180 сая төгрөгөөр тохижуулсан гэж үнэн үү. Төр уг нь хэмнэлтийн бодлого барьж байгаа. Гэтэл нэг дарга нь 180 сая төгрөгөөр байр тохижуулж, бүр долоон зөвлөхтэй ажилладаг гэх юм. Тийм олон зөвлөхийн хэрэг танд байна уу?**

-“Эрдэнэт үйлдвэр”–ийн ерөнхий захирал, орлогч нарт өмнө нь шинээр байр бариад өгсөн тохиолдол байсан. Бэлэн байрнаас ч худалдаж аваад өгчихдөг юм байна лээ. Тэр жишгээр явсан асуудал. Энд Х.Бадамсүрэн гэдэг хүн очоод тансагласан зүйл байхгүй. “Эрдэнэт үйлдвэр” хэмнэлтийн бодлогоо барьж ажиллаж байгаа. Манай үйлдвэр хоногт 1.5 сая ам.долларын бүтээгдэхүүн үйлдвэрлэж байна. Ерөнхий захирлын тавилга, машин ч гэх шиг асуудал байна. Машины хувьд “Эрдэнэт үйлдвэр”–ийн өмнөх захирал “Лексус-570” унаж байсан юм байна лээ. Би арваннэгдүгээр сарын 30-нд ажлаа авсан. Гэтэл энэ машины асуудал арваннэгдүгээр сарын 20-ны үеэр яригдсан юм байна лээ. Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын шийдвэрээр “Эрдэнэт үйлдвэр”–ийн өмнөх захирлын машин өөр газар шилжих болж, түүний оронд шинэ машин авах болсон. намайг ажлаа авах цаг үетэй санамсаргүй давхацсан хэрэг. Тэрнээс биш Ц.Даваацэрэн захирлаар үлдсэн, эсвэл өөр нэг Дорж очсон ч тэр шинэ машиныг унах байсан. Би хөрөнгө мөнгөнд дурладаг, эсвэл машинд хорхойтой учраас авсан хэрэг биш. Намайг ямар хүн бэ гэдгийг энд сууж байгаа та бүхэн бүгд л мэдэх учиртай.

**-Зөвлөх болон туслахынхаа талаар яриач. Та орос туслахтай юм билээ. Монгол хүнийг ажлын байраар хангаж болохгүй юу?**

-Та бүхэн мэдэж байгаа. Энэ үйлдвэр төрд ирэхээс өмнө ОХУ-ын хамтарсан үйлдвэр байсан. Тэр ч утгаараа маш олон орос ажилчид байгаа. Эрдэнэт хотод ажил амьдралаа төвхнүүлчихсэн, мэргэжлийн дагуу ажлаа хийгээд явж байгаа хүмүүс олон бий. Гэтэл би очоод, эсвэл төрд ирлээ гээд шууд тэднийг хөөгөөд явуулчихаж болохгүй. Хоёр улсын найрамдалт харилцааны асуудал байна. Цэргийн ангийн асуудлаас болж манайх ОХУ-тай таарамжгүй харилцаатай болж байсан тохиолдол бий. Зөвлөхүүд бүгд тус тусдаа ажил үүргийн статустай. Тэд надад зөвлөх гэхээс илүүтэй салбар хэлтсүүдэд мэргэжил аргазүйн зөвлөгөө өгч, уялдаа холбоог хангаж ажиллах үүрэгтэй. Тэдэнд сард 10 сая төгрөгийн цалин өгдөг гэх юм. Тийм зүйл байхгүй ээ. Тэд Хөдөлмөрийн гэрээнд заасны дагуу сардаа 2.5 сая төгрөгийн цалин авдаг.

**-Таны тухайд хэдэн төгрөгийн цалинтай вэ. Төрийн өмчийн компанийн захирал атлаа ам.доллараар цалинжиж болох уу?**

-Тийм асуудал байхгүй ээ. Надад тогтоож өгсөн цалин нь гурван сая төгрөг. ТУЗ-ийн гишүүдийн цалинг минийхтэй хамт яриад байсан.

**-10 мянган ам.долларын цалин өгнө гэж тохирсон гэж Ц.Ням-Осор дарга ярьсан нь худлаа гэсэн үг үү?**

-Би тэрнийг мэдэхгүй

**-“Эрдэнэт үйлдвэр”-т цаашид шахааны бизнес хийхгүй гэж найдаж болох уу?**

-Найдаж болно. нэг ч ийм асуудал гаргахгүй гэдгээ хариуцлагатайгаар хэлье. Тэгж ажиллаасай гэж төр намайг томилсон. Шахааны Эрдэнэт биш шил тол шиг ариун тунгалаг Эрдэнэт болгоно. Тодорхой хугацаанд мэдээлэл өгөөд явсан ч болж байна. Ер нь Эрдэнэт үйлдвэрийн үйл ажиллагааг хэвийн явуулах, ашигтай байлгах үүднээс олон зүйл хийнэ гэж бодож байгаа. 15 жилээр хэтийн төлөвлөгөөгөө гаргана. Бид ашигтай ажиллаж байгаа ч өмнөх оны өрнүүд том асуудал болж байна. 20 гаруй жил яригдсан Казакстантай холбоотой асуудал байна. Гадаад харилцааны яамтай хамтарч хөөцөлдөж явсаар гурвалсан гэрээ байгууллаа. Мөн Ц.Даваацэрэн захирлаас ч өмнө гэрээний үүргээ биелүүлээгүй гэдэг шалтгаанаар 7-8 сая ам.долларын төлөх өрөнд орчихсон байдаг. Тэр байтугай “Эрдэнэт үйлдвэр”-ийн удирдлага Англи улсад хөл тавих юм бол саатуулна гэсэн мэдэгдэл ирс байсныг, долоон сая орчим ам.доллараа төлж тэнд царцаагдсан 20 гаруй сая ам.доллараа эргэлтэд оруулах нөхцөл боломжоор хангалаа. Ажлаа авснаас хойш ашигтай ажиллуулахын төлөө л явж ирлээ. Тухайлбал, нэгдүгээр улирлын байдлаар техник технологийн бүх үзүүлэлтийг 100-аас дээш хувиар биелүүлсэн. Нэгдүгээр улиралд 84 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан. Ингээд улс, орон нутгийн төсөвт 188 тэрбум төгрөг төвлөрүүллээ.

## Мэдэгдэл

*Засгийн газраас УИХ-д өргөн мэдүүлсэн Зөрчлийн тухай хуульд хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндийн асуудлаар гарсан зөрчилд 10-100 сая хүртэл төгрөгийн торгууль ногдуулахаар тусгасан нь эдийн засаг, эрх мэдэл, улс төрийн цагдан хяналт бөгөөд ардчиллын амин сүнс болсон иргэдийн мэдэх эрх, хэвлэл мэдээллийн эрх чөлөөнд халдсан ноцтой үйлдэл гэж бид үзэж байна.*

*Үндсэн хуулиар олгогдсон иргэдийн мэдээлэл олж авах, түгээх, үзэл бодлоо илэрхийлэх эрхийн эсрэг аливаа үйлдлийг Монголын хэвлэл мэдээлэл, сэтгүүл зүйн салбарт ажиллагсад туузтай эсэргүүцэх эв санааны нэгдлээ энэхүү мэдэгдлээр илэрхийлж байна.*

*Сэтгүүл зүй, хэвлэл мэдээллийн салбарын үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомж батлан гаргахдаа мэргэжлийн холбоод, хэвлэл мэдээллийн хэрэглүүдийн саналыг заавал авч тусгадаг улс төрийн соёлыг сэргээхийг УИХ, Засгийн газраас шаардаж байна.*

**Монголын сэтгүүлчдийн нэгдсэн эвлэл**
**Хэвлэл мэдээллийн зөвлөл**
**Өдөр тутмын сонинуудын холбоо**
**Монголын телевизүүдийн холбоо**
**Монголын эрэн сурвалжлах сэтгүүлчдийн холбоо**
**Мэдээллийн сайтуудын ассоциаци**
**Монголын үндэсний сайтын хөгжлийн нэгдсэн холбоо**
**Мэдээллийн тэргүүлэгч сайтуудын холбоо**
**Монголын сайтын холбоо**
**Хэвлэл мэдээллийн эздийн холбоо**
**Глоб интернэшнл ТББ**

MMINFO.
МОНГОЛЫН МЭДЭЭ
19 дэх жилдээ

Ерөнхий эрхлэгч: С.ГАНТОГОО
Орлогч эрхлэгч Ч.ЧУЛУУНЦЭЦЭГ 99189158
Хариуцлагатай нарийн бичгийн дарга: Э.ЭНХЦЭЦЭГ 90873012
Ахлах редактор: Б.ӨНӨРТОГТОХ 88006842
Шуурхай мэдээлэл, эрэн сурвалжлах алба Н.ПУНЦАГБОЛД 88096454
Улс төр, гадаад мэдээлэл, эдийн засгийн алба: Б.ӨНӨРТОГТОХ 88006842
Гэрэл зургийн алба: Г.АРГУУЖИН 96017873
Компьютерийн алба: Б.ГАНЗОРИГ 99998796
Маркетинг, зар сурталчилгааны алба: Н.АЛТАНЦЭЦЭГ 99173710
Захиалга, борлуулалтын алба: М.ДАВААДУЛАМ 99042510
Э.САЙНЗАЯА 99197866
Дугаарыг эрхэлсэн Н.ПУНЦАГБОЛД

Улсын бүртгэлийн дугаар: 907300528
Индекс: 100757

Редакцийн хаяг:
Улаанбаатар хот. Сүхбаатар дүүрэг. Чөлөөт хэвлэл сан /Хэвлэлийн хүрээлэн/. 2 давхар. 209, 211 тоот

“Монголын мэдээ” сонины редакцид эхийг бэлтгэж, “Чөлөөт хэвлэл сан”-ийн хэвлэх үйлдвэрт хэвлэв.

# ҮЗЭЛ БОДОЛ



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

# Ерөнхийлөгчийн сонгууль ба АН-ЫН ХУВЬ ЗАЯА

Б.ӨНӨРТОГТОХ

Ерөнхийлөгчийн сонгуулийн дуулиан хаврын улс төрийн халуухан сэдэв болчихож. Ардчилсан Монгол Улсыг удирдах чин хүсэл, нөгөө талаар мөрөөдөл тээсэн хүмүүс улс төрийн намууд дунд бишгүй олон гэдэг нь хэвлэлээр яригдаж буй горилогчдын жагсаалтаас илхэн харагдана. Нам болгон дотроо ил далд өрсөлдөөн явуулж, дотоодын дэмжлэг авахын тулд сэм, сэмхэн уулзалтууд хийж байгаа сурагтай. Хууль ёсоор Монгол Улсын Ерөнхийлөгчид нэр дэвшигч тавдугаар сарын эхний 10 хоногт тодрох учиртай. Улмаар, тавдугаар сарын 17-нд СЕХ-ноос нэр дэвшигчдийг албан ёсоор нийтэд зарлах хуулийн заалттай юм билээ. Гэтэл хуулийн хугацаа болоогүй байхад өөрийгөө Ерөнхийлөгч хэмээн сэтгэчихсэн хүмүүс “би ялчихвал, ингэж ажиллана, тэгж өөрчилнө” хэмээн амлалт өгөөд л давхиж явна. Зангараг заагаад ч тэр үү МАН-ын горилогчдын сурталчилгаа тун ч нууцхан байдалтай. Хаа нэгхэн асуудлаар “шоудаж”, хэвлэл мэдээллийн анхааралд өртөхөөс өөрөөр мэдэгдсэн зүйл алга. МАХН-ынхан ч ялгаагүй санал тавих хэмжээнд л тохиролцоо хийж буй сураг дуулдах болсон. Өөрөөр хэлбэл, наашаа гэсэн бүхэнтэй найр тавин уулзаж, нам харгалзахгүй хэнийг ч дэвшүүлэх магадлалтай гэдгийг МАХН-ын нэр бүхий улстөрчид хэлж буй юм. Хувьсгалт намын нэр хүндийг өндөрт өргөж чадах, хувь хувьсгалын асуудлаар даацтайхан үзэл бодлоо илэрхийлчих хэнийг ч МАХН хүлээж авахад бэлэн байгаа юм билээ. Тиймээс МАН-д гологдсон нэг нөхөр МАХН руу давхиж очоод нэр дэвшчихвэл гайхах зүйл алга.

## Эрх мэдэл, мөнгө бүгд МАН–ын талд байна, харин АН...

Ерөнхийлөгч болох хэтийн мөрөөдлөө ажил хэрэг болгочих зорилготой, дотоодын дайнаа ил тод зарлачихсан улс төрийн хүчин бол АН-ынхан. 100 ямаанд 60 ухна гэгчээр “том мөрөөдөл”-тэй хүмүүс энэ намд хэтэрхий олон юм. Бүгд л дор бүрнээ амбийц, алдар нэрийн хойноос хөөцөлдөж нэгэн цул болох гэж оролдож буй намаа нэлээд олон хэсэг болгон бутаргахдаа ч гарамгай юм. Урьдчилсан байдлаар АН-аас долоон горилогчийн нэр дуулдаж эхэлжээ. Уламжлал ёсоор фракци, фракцийн төлөөлөл өрсөлдөнө гэсэн үг. Бүр өөр намаас орж ирчихээд Ерөнхийлөгч болох мөрөөдөл ч тээж яваа хүн ч тэдэн дунд дуулдах болов. Гэхдээ энэ удаагийн сонголт АН улс төрийн тавцанд нам хэвээр үлдэх үү, нэр хүндээ навс унагаж, дахиад 20 жил гудамжинд лааз өшиглөх үү гэдгийг шийдэх хариуцлагатай цаг үе. Намын даргаа сонгосон шиг фракцийн улс төр хийж, гишүүдийн бүртгэл нэрээр хуурамч анкет бүрдүүлж, ядарсан гишүүдийнхээ саналыг 5000 төгрөгөөр үнэлэх юм бол ардчилал дахиад хэзээ ч өндийхгүй. Тэртээ тэргүй МАН бүх шатанд хүчтэй байгаа. МАХН-ынхан ч ярьснаасаа буцаж МАН-тай тохиролцоонд хүрч, улмаар сонгуульд оролцохоос татгалзах, эсвэл МАН-ын нэр дэвшигчид боломж олгох үүднээс эсрэг сул өрсөлдөгч сойвол АН-д ямар ч шаанс гарахгүй. Эрх мэдэл, мөнгө гээд бүх зүйл МАН-д ашигтай байгаа учраас энэ бүхний өөдөөс АН нэр цэвэр хүнийг л явуулах учиртай юм. Улс төрд мэдээж өндөг шиг өөгүй хүн байхгүй. Гэвч улс төрийн туршлага, зангараг, адаглаад л мэдлэгтэй улстөрчийг сойхгүй л бол АН хоёр том сонгуульд бүрэн ялагдал хүлээх нь ээ. Ардчилсан Ерөнхийлөгчтэй болчихлоо гэхэд Ардын намын хэмжээ хязгааргүй эрх мэдэлд хяналт тавих хүнтэй болно гэсэн үг. Олонхиор хүч түрээд баталчихсан хуулийг хориг тавиад ч болов хойшлуулах сөрөг хүчний дуу хоолой төрд хүчтэй болох учиртай. Тиймээс л Ерөнхийлөгчийн сонгуульд намын зөрчил, фракцийн эрх ашгийн үүднээс биш ирэх сонгуулийн үр ашиг, ирээдүйд олж авах нэр хүндийнхээ төлөө нэгдэх хэрэгтэй байна, АН-ынхаан. Мэдлэгтэй, чадвартай, хамгийн чухал нь нэр цэвэр гэсэн шалгуурт тэнцэх хүн эдгээр долоон горилогчид дунд харамсалтай нь ганц, нэгхэн байгаа. Дийлэнхи, олонхи нь муу нэртэй, луу данстай. Зангарагтай улстөрч шүү гэж хэлчихмээр, тоочихмоор хүн чамлалтай.

## Фракцийн дарга нар намаа ялагдуулахыг хүсэв үү

Хамгийн хачирхалтай нь АН-ынхан ирэх тавдугаар сарын 2-нд намын гишүүдийнхээ дотоод сонгуулиар нэр дэвшигчээ тодруулна гэж зарлачихсан. Цаг хугацаа тулчихсан, хэзээ мөдгүй шинэ сар гарах гэж байхад нэр дэвшинэ ээ гэж зарласан улстөрчдөөс даацтай хөдөлгөөн хийсэн хүн тун цөөхөн байгаа нь олны гайхшийг төрүүлж буй. Эндээс харахад, АН Ерөнхийлөгчийн сонгуульд тэгтлээ ач холбогдол өгөхгүй байна уу хэмээн хардаж болохоор. Намын гишүүд дунд ч иймэрхүү яриа гарч байгаа нь худлаа биш. АН-ын дотоод зөрчил туйлдаа хүрчихсэн нь хэнд, илхэн. Тиймдээ ч намаа даргалж буй “Шонхор” фракци ба бусад гэсэн зөрчлийн үр дүн Ерөнхийлөгчийн сонгууль байх нь гэсэн таамаг яриаг үгүйсгэж боломгүй юм. Намын шинэчилсэн дүрэмдээ сонгуульд намаа ялагдуулсан бол намын удирдлага хариуцлага хүлээх ёстой гэсэн заалт байгаа гэх. Тиймээс бусад фракциуд Ерөнхийлөгчид намаа ялагдуулж, улмаар С.Эрдэнэ даргатай хариуцлага тооцох тохироог ч наагуур цаагуур хийгээд эхэлсэн гэсэн явган яриа нэг биш нэлээд хэдэн хүний амнаас дуулдаж буй учраас үнэний магадлал өндөр гэсэн үг л дээ. Фракцийн дарга нар ярилцаж, ийм шийдэлд хүрсэн байлаа гэхэд АН гоё харагдах нь юу л бол. С.Эрдэнийг түлхэж унагалаа гээд АН шинэчлэгдэж чадах эсэх нь эргэлзээтэй. Дараа, дараагийн сонгуульд ялалт байгуулах магадлал буурна уу гэхээс өснө гэсэн итгэл төрөхгүй нь. АН-ын лидер гэгдэх улстөрчид арай ч намаа ингэж хорлохгүй гэж найдъя. Ардчилсан намд итгэдэг, улсын хөгжилд хэрэгтэй хэмээн дэмждэг мянга, мянган гишүүдийнхээ итгэл рүү ус цацахгүй гэж найдъя. Харин нэг нам шиг эвлэлдэж, намаа хагалан бутаргах бус нийтээр нэр цэвэр улстөрчөө дэмжээд явчихвал АН ард түмэнд гоё харагдана даа. Төрийн жолоог нэг намд дангаар өгч болохгүйг ард түмэн мэдэж буй учраас АН-ын нэр дэвшигч ялах магадлал өндөр гэдгийг тэд мэдэж байгаа биз ээ.

Дугаарын 60 мөр

# Ходоод дурандуулах зовлон биш

Э.ТУУЛ

“Муу эмд уйлах зав олдохгүй” гэгчээр хүн бүхэн л их ажилдаа дарагдан өдрийн хоолоо ч идэх завгүй байсан тухайгаа ярьдаг. Амрыг нь бодож, бэлэн гоймон дэвтээгээд идчих бол энгийн л үзэгдэл. Ядаж монголчууд өглөөний цай ууна гэж бараг л байдаггүй. Зарим нь ажилдаа дарагдсаар оройтож, хариад шөнө хоол идэх нь ч бий. Ажлынхаа ойролцоох хүнсний дэлгүүрээс он сарыг нь ч сайн харалгүй бэлэн бүтээгдэхүүн хам хум авч гараад, ажлаа хийх зуур, компьютерийн дэлгэцээ ширтсээр хооллох тохиолдол ч байнга шахам давтагддаг. Ийм л зөв, зохисгүй хооллолт эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөхийн зэрэгцээ ходоодонд бүр ч ихээр “дарамт учруулж” байгаа юм. Угтаа бол өдрийн хоолондоо цаг зав гаргахгүй, залгиж идсэн хоол идээгүйтэй адил үр дүнтэй бөгөөд хоолны чанарын талаар яриад ч хэрэггүй. Сүүлийн үед Монгол Улс ходоодны хорт хавдраар дэлхийд тэргүүлж эхэлсэн гэх мэдээлэл бий. Тэгвэл зүрх судасны өвчин, чихрийн шижин, ходоодны хорт хавдрын гол үндэс нь ерөөсөө л зохисгүй хооллолт юм байна. Түүнчлэн ходоодонд байнга ачаалал өгснөөс болж хоол боловсруулах эрхтэн системийн өвчин эмгэгтэй болж, ходоодны тэр элдэв эмгэгүүд хүндрэхээрээ хорт хавдар үүсгэдэг байна. Тэгэхдээ ходоод нь өвддөг хүн бүр хавдар туссан гэж ойлгож болохгүй. Ходоодны шарх эсвэл үрэвсэлтэй бол түүнийгээ даруйхан оношлуулах, эмчлүүлэх хэрэгтэй гэдгийг эмч, мэргэжилтнүүд байнга хэлдэг. Үүнээс гадна ходоодны үрэвслийн гол шалтгаан бол хеликобактери юм. Өндөр хөгжилтэй орнуудын хүн амын 15-30 хувь орчим, хөгжиж буй орнуудын хүн амын 70 орчим хувь нь энэхүү нянгаар халдварлагдсан байгааг судлаачид тогтоосон байдаг. Харин манай орны эрдэмтдийн судалгаагаар насанд хүрэгсдийн 74-82, өсвөр насны хүүхдүүдийн дунд 64 хувь нь хеликобактерийн халдвартай байгаа учраас ХСҮТ-өөс энэ жил “Элэг бүтэн Монгол-2” хөтөлбөрийг хэрэгжүүлж, ходоодны хорт хавдартай “дайтах”-аар шийдсэн. Гэтэл иргэдийн дунд “Ходоод дурандуулах нь муу. Шархтай бол түүнийг нь сэдрээдэг” гэсэн буруу ойлголт их байдгаас ихэнх хүмүүс ходоодоо дурандуулахаас айж, эцэст нь хүндрэх тохиолдол ч бий. Үнэндээ орчин үед техник технологи өндөр төвшинд хүрч, эмч мэргэжилтнүүдийн ур чадвар сайжрахын хэрээр оношлогоо эмчилгээ ч дагаад сайжирч буй. Хоол боловсруулах эрхтний өвчний оношлогоо, эмчилгээнд уян дурангийн арга тэргүүлэх ач холбогдолтой төдийгүй үүгээр хоол боловсруулах замын хавдрыг эрт үед нь оношлох боломж нэмэгдсэн гэнэ. Ерөнхийдөө 45-аас дээш насны хүмүүс ходоодны дуранд жилд нэг удаа, бүдүүн гэдэсний дуранд хоёр жилд нэг удаа орох шаардлагатай гэж үздэг байна. Харин ямар ч насны хүн цээж хорсох, аюулхай дээр цанхайх, хоол шингэхгүй, горойх гэх мэт хоол боловсруулах эрхтний талаас ямар нэг зовиур илэрч л байгаа бол зайлшгүй дурангийн шинжилгээ хийлгэх нь зүйтэй аж. Сүүлийн үеийн дурангийн багажууд хоол боловсруулах замын эрхтний салстыг будаж хардаг технологи бүхий давуу талтай болсон бөгөөд энэхүү аргаар ходоодны салстын гадаргуу дахь эмгэг, өөрчлөлт, түүний судасны бүтцийг илүү нарийвчлалтай харснаар улаан хоолой, ходоодны хорт хавдрыг эрт үед нь илрүүлэх боломжтой гэж эмч зөвлөж байна. Тэгээд ч одоо бүдүүн хатуу гуурс ам руу нь чихэж, огиулж зовоодог байсан нь аль хэдийнэ ард хоцорчээ. Уг дуран нь үзүүр дээрээ видео камертай ч хатуу дуран учир улаан хоолой болон ходоодыг багана мэт нэг чигт байрлуулж байгаад дурангаа оруулдаг их хүнд шинжилгээ байсан аж. Харин одоо анагаах ухаанд хэрэглэж буй дуран хүний биеийн 36-37 хэмийн халуунд ороод илүү уян хатан болж, хөдөлгөөнөөр гулсаж ордог болсон аж. Түүнчлэн гадны улс, оронд өндөр өртөгтэйд тооцогддог дурангийн оношлогоог манайд ЭМД-ын дэвтэртэй, түүнийгээ бөглүүлсэн хүн бүр Улсын клиникийн I, II, III эмнэлэг, ХӨСҮТ, дүүргүүдийн нэгдсэн эмнэлэгт үнэ төлбөргүй хийдэг аж. Үнэндээ өндөр хөгжилтэй орнуудад иргэд нь өвчнөө эрт үед нь оношлуулж үр дүнтэй эмчилгээ хийлгэдэг учраас нас баралт бага байдаг бол манайд эсрэгээрээ ам дамжсан яриа, таарч тохирох эсэх нь мэдэгдэхгүй эмчилгээг өөрөө дур мэдэн хийсээр өвчнөө хүндрүүлчихээд, эцсийн шатандаа эмнэлэгт, эмчид хандах нь их. Энэ бол манай иргэдийн эрүүл мэндийн боловсрол маш сул байгаатай л холбоотой. Тиймээс та ходоодоо дурандуулахаар шшийдсэн бол орой 17:00 цагаас хойш мах махан бүтээгдэхүүн идэж болохгүй. Мөн өглөө босоод юу ч идэж, уухгүй өлөн очих хэрэгтэй. Хэрэв тамхи, татдаг бол тамхи ч хэрэглэж болохгүй. Эдгээрийг баримтлаагүйгээс ходоодонд шүлс, хүчил ялгараад шинжилгээний хариу буруу гардаг гэдгийг эмч хэлж байна билээ. Ер нь ч тэгээд “хоол олдоно, ходоод олдохгүй” гэдэг үг байдаг болохоор зөв, зохистой хооллож чадахгүй бол ядаж эрт оношлуулахад нэг их буруудахгүй л болов уу.

ӨНӨӨДРИЙН ТОП ИШЛЭЛ




Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

# ДЭЛХИЙ

## Тайландын эзэн хааныг аравдугаар сард чандарлана

Тайландын Засгийн газраас өчигдөр мэдээлэл хийж, өнгөрсөн оны аравдугаар сард таалал төгссөн эзэн хаан Пхумипон Адульядетыг нутаглуулах товыг зарлажээ. Тодруулбал, ирэх аравдугаар сарын 26-нд албан ёсоор оршуулгын ёслолыг зохион байгуулах гэнэ.

Таалал төгссөн эзэн хааны шарилыг нийслэл Бангкок хотын хааны ордны өмнө байрлах талбайд чандарлахаар болжээ. Түүнчлэн, мөн өдрийг бүх нийтийн амралтын өдөр болгохоор болсон байна.

Тайландын эзэн хааны сэнтийд 70 жил заларсан эзэн хаан Пхумипон Адульядет өнгөрсөн оны аравдугаар сарын 13-нд 88 насандаа таалал төгссөн. Улмаар тус улс нэг жилийг гашуудлын жил болгон зарласан байдаг. Одоогийн байдлаар тус улсын зургаан сая орчим иргэн Бангкок дахь Гранд Паласт зочилж, эзэн хаантай салах ёс гүйцэтгээд байгаа аж.

## Хятад анхны дотоодод үйлдвэрлэсэн нисэх онгоц тээгчээ далайд гаргалаа



БНХАУ анхны дотоодод үйлдвэрлэсэн нисэх онгоц тээвэрлэгч 001А загварын хөлгөө өчигдөр далайд гаргажээ. Энэ талаар тус улсын төрийн мэдлийн "Синьхуа" агентлаг мэдээлжээ. БНХАУ-ын тухайд хоёр дахь, харин дотоодоо үйлдвэрлэсэн анхны нисэх онгоц тээвэрлэгч болох уг хөлгийг далайд гаргах ёслолын ажиллагаа Ляонинь мужийн Далянь боомтод зохион байгуулагдсан байна.

Шинэ хөлөг 315 метр урт, 75 метр өргөн хэмжээтэй, 50 мянган тонн жинтэй. Хөлөгт мөн тус улсад үйлдвэрлэсэн "J-15" онгоцыг тээвэрлэжээ.

1998 онд Украинаас дутуу үйлдвэрлэгдсэн Зөвлөлтийн Варяг хөлгийг худалдан авч, засаж сэлбээд 2012 оны есдүгээр сараас "Ляонинь" нэрээр ашиглаж ирсэн байдаг. Тэр нь өнөөдрийг хүртэл Хятадын Ардын Чөлөөлөх Армийн цорын ганц тээвэрлэгч байжээ.

Тэгвэл шинэ тээвэрлэгчийг үйлдвэрлэх ажил таван жилийн хугацаанд үргэлжилсэн байна. Хэдийгээр Хятад улс хоёр тээвэрлэгчтэй болсон ч гол өрсөлдөгч АНУ-аас тэнгисийн цэргийн хүчин чадлын хувьд хол хоцорсон хэвээр байна. Гэхдээ мэргэжилтнүүд өчигдөр болсон хөлгийг далайн усанд гаргах ёслолын ажиллагааг бэлгэдлийн чанартай гэдгийг тодотгожээ. Тодруулбал, тус хөлөг ажлын туршилтаа хийх хүртэл цаашдаа хоёр жилийн хугацаа зарцуулах гэнэ.

## БНСУ-д иргэд цагдаа нартай мөргөлджээ

АНУ-ын армийн хамгийн сүүлийн үеийн пуужингийн довтолгооноос хамгаалах систем "THAAD"-ын хэсгүүдийг тээвэрлэсэн зургаан ачааны машин өчигдөр өглөө БНСУ-ын хойд Гёнсан мужийн Сёнжу дүүргийн гольфийн талбайд хүрчээ. Энэ талаар Ёнхап агентлаг мэдээлсэн бөгөөд тус телевизийн бичлэгт THAAD системтай адил техникийг ачсан том оврын зургаан ачааны машин гольфийн талбайд ирж буй байдал дүрслэгдсэн байна.

Гэтэл ачааны машиныг тухайн хэсэгт очих үед байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг нь эсэргүүцсэн энгийн хэдэн зуун иргэд эсэргүүцлийн хөдөлгөөн зохион байгуулж, цагдаа нартай мөргөлджээ. Төрөлх газар нутагт нь аюултай зэвсэг байрлуулахыг хэдэн сарын турш эсэргүүцсэн иргэд зургаан ачааны машинд тээвэрлэж ирсэн эд ангиудыг нэвтрүүлэхгүйн төлөө тэмцсэн нь энэ юм. Энэ удаагийн эсэргүүцлийн хөдөлгөөнд THAAD-ыг байрлуулах газрын ойролцоо амьдардаг 8000 орчим иргэний 200 нь эсэргүүцлийн ажиллагаанд оролцож, эмх замбараагүй байдал үүсгэсэн тул цагдаа нар хүчээр зохицуулахаас өөр аргагүйд хүрсэн байна. Иргэд THAAD системийг нутаг дэвсгэрт нь байрлуулснаар өөрсдийгөө Хойд Солонгосын довтолгооны гол бай болохоос гадна хүн амын эрүүл мэнд, байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлнэ гэж үзэж байгаа аж. Гэвч, БНСУ-ын Батлан хамгаалахын сайд THAAD системын тээвэрлэлтийг нэн яаралтай бүрэн ажиллагаанд шилжүүлэх байр суурийг илэрхийлсэн байна.



# ЯПОНЫ САЙДЫН УРТ ХЭЛ ХҮЗҮҮГ НЬ ОРООЛОО

Б.ДАВАА

Японы Шинзо Абэгийн Засгийн газрын Гамшгийн дараах сэргээн босголт хариуцсан сайд Либериал ардчилсан намын үйл ажиллагааны үеэр зүүн Японы гамшгийн дараах бүтээн босголттой холбоотой үг хэлжээ. Ингэхдээ "Цунами зүүн хойд хэсэгт нүүрлэсэн нь сайн хэрэг" гэж хэлснийхээ төлөө огцорсон байна. Цунамигийн гамшигт өртөн хайртай дотны хүмүүсээсээ хагацаж үлдсэн хохирогчдын сэтгэлийг эмзэглүүлэх болчимгүй үг хэлснийхээ хариуцлагыг хүлээн тэрбээр огцрохоор шийдэн, өргөдлөө өгчээ.

Харин Ерөнхий сайд Шинзо Абэ түүний өргөдлийг хүлээн авч, ажил царгалдуулахгүй байх үүднээс нэн яаралтай орных нь хүнийг томилох байр сууртай байгаа "NHK" агентлаг мэдээлжээ. Хамгийн сүүлд авсан мэдээллээр Масахиро Имамурагийн албан тушаалд Либериал Ардчилсан намын улсторч Масаёши Ёшиног томилжээ.

Сэргээн босголт хариуцсан сайд Масахиро Имамура энэ сарын 25-ны өдрийн үдэш Либериал Ардчилсан намын үйл ажиллагаанд оролцож, үг хэлсэн байна.

Тухайн үед тэрбээр зүүн Японы гамшгийн дараах бүтээн байгуулалттай холбогдуулан

"Гамшгийн учруулсан хохирлын хэмжээ 25 их наяд иэн. Харин ч зүүн хойд хэсэгт цунами болсон нь сайн хэрэг шүү. Токиогийн орчимд болсон бол яана. Хохирлын дүн нь 25 их наядаас ч илүү их хэмжээнд гарах байсан байх " гэж хэлжээ.

Улмаар ам алдвал барьж болдоггүй гэдгийн үлгэрээр дээрх үг хэлснийхээ дараа сайд хэдэнтээ уучлал гуйсан байна. Үүгээр зогсохгүй дараа нь Ерөнхий сайд Шинзо Абэ мөн ижил үйл ажиллагаанд оролцож үедээ "Японы зүүн хойд хэсгийн ард түмний сэтгэлийг эмзэглүүлэх болчимгүй үг хэлснийх нь төлөө би Ерөнхий сайдынхаа хувиар уучлалт хүсч байна" хэмээн мэдэгдэж, мөн л толгой бөхийлгөн уучлалт хүсчээ.

> ...Үүгээр зогсохгүй дараа нь Ерөнхий сайд Шинзо Абэ мөн ижил үйл ажиллагаанд оролцох үедээ "Японы зүүн хойд хэсгийн ард түмний сэтгэлийг эмзэглүүлэх болчимгүй үг хэлснийх нь төлөө би Ерөнхий сайдынхаа хувиар уучлалт хүсч байна" хэмээн мэдэгдэж, мөн л толгой бөхийлгөн уучлалт хүсчээ...

Гамшгийн дараах сэргээн босголт хариуцсан сайд Масахиро Имамурагийн үгний алдааг сөрөг хүчнийхэн ч шүүмжилж, байгалийн гамшигт үзэгдлийн хохирогчдыг гомдоох үг хэлснийхээ төлөө сайд огцрох ёстой гэсэн мэдэгдэл гаргажээ. Ийнхүү намын үйл ажиллагаанд хэлсэн болчимгүй үгнийхээ хариуцлагыг хүлээн Масахиро Имамура сайд огцрох өргөдлөө гаргасан байна. Үүнийхээ дараа тэрбээр сэтгүүлчдэд "Би зүүн хойд нутгийн ард иргэдийн сэтгэлийг эмзэглүүлэх үг хэлсэндээ харамсаж, гүнээ уучлал гуйж байна" гэж ярьжээ.

Сэргээн босголт хариуцсан сайд Масахиро Имамура Кюушюгээс нийтдээ долоон удаа сонгогдсон байна. Эдүгээ 70 насны босго алхсан тэрбээр өнгөрсөн хугацаанд Хөдөө аж ахуй, загас агнуурын яамны дэд сайд, төлөөлөгчдийн танхимын зүүн Японы гамшгийн дараах сэргээн босголт хариуцсан тусгай комиссын даргаар ажиллаж байгаад, шинэ Засгийн газар томилогдоход сэргээн босголтын сайдаар томилогджээ.

2011 онд Японы зүүн этгээдэд болсон гамшгийн улмаас 15893 хүн амиа алдаж, 2553 хүн сураггүй болсон юм.

# АН-ЫГ "АМЬД ҮЛДЭЭХ" Д.ДОРЛИГЖАВЫН БОДЛОГЫГ АРД ТҮМЭН ТААЛАХ УУ

С.ӨРНӨЛ

Намууд Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигчээ тодруулах хаврын улс төр ид дундаа явна. Хуулиараа парламентад суудалтай намууд өөрийн төлөөллөө Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшүүлэх эрхтэй. Мэдээж тэдний өрсөлдөх албан тушаал нэг л хүнийх учраас нам тус бүрээс нэг л хүн нэр дэвшиж таарна. Энэ удаагийн сонгуульд МАН, АН, МАХН гэсэн гурван нам төлөөллөө нэр дэвшүүлнэ гэсэн үг. Харин аль намаас, хэн нэр дэвших вэ гэдэг асуултын хариулт түн удахгүй тодорхой болно. Өөрөөр хэлбэл, ирэх сарын 5 гэхэд нэр дэвшигчдийн нэрс тодорхой болсон байх учиртай. Тиймээс ирэх долоо хоногийн сүүл гэхэд аль намыг хэн төлөөлж төрийн тэргүүний төлөө өрсөлдөх вэ гэдэг нь нэг мөр болно. Тиймээс яг энэ цаг мөчид ч намууд энэ асуудлаар зөвшилцөж байгаа. Эрх баригч хүчний хувьд нэгдсэн тохироонд хүрсэн гэх мэдээлэл бий. Харин хамгийн их анхаарал татаж байгаа нь парламент дахь сөрөг хүчин АН-аас хэн нэр дэвших вэ гэдэг асуудал. Учир нь өнөөдрийн байдлаар тус намаас найман ч хүн нэр дэвших хүсэлтэйгээ илэрхийлсэн, сонгуулийнхаа пи-арыг хүртэл хийгээд эхэлсэн. Харин намын дарга С.Эрдэнийн хувьд бүх гишүүдийн санал хураалтаар Ерөнхийлөгчид нэр дэвшигчийг тодруулна гэдгээ зарлачихаад байгаа. Энэ бүхнээс үзэхэд АН дотор ширүүхэн тулаан өрнөх нь нэгэнт ойлгомжтой болоод байна. Энэ намаас нэр дэвшигчдийг тус бүрт нь аваад үзвэл сонин дүр зураг харагдана. Нэг үгээр хэлбэл, албан тушаалын "амт"-ыг мэддэг хүмүүс нэрээ дэвшүүлэхээ илэрхийлчихээд байгаа. Тухайлбал, хамгийн сүүлд хотын даргаар ажиллаж байсан Э.Бат-Үүл, Ерөнхий сайд асан Н.Алтанхуяг, УИХ-ын гишүүн асан Р.Амаржаргал, Зам тээврийн сайд, УИХ-ын гишүүн асан Х.Баттулга, Хууль зүйн сайд асан Д.Дорлигжав нарыг дурдаж болно. Цаашилбал, УИХ-ын гишүүнээр ажиллаж байсан Г.Батхүү, Л.Болд нар ч Ерөнхийлөгчийн сонгуульд битүүхэн санаархаж яваа. Нэр дурдсан хүмүүсийг аваад үзвэл бүгд л төрийн дээд албан тушаал хашиж явсан эрхмүүд. Хэрвээ хүн албан тушаалд цаддаг бол аль хэдийнэ зайгаа тавиад өгөхөөр болчихсон улс харагдаад байгаа юм. Өөрөөр хэлбэл, УИХ-ын гишүүн, сайд, Монгол төрийн гурав дахь том албан тушаалыг хүртэл хашиж явсан эрхэм улам бүр суудал ахиад Ерөнхийлөгч болохын төлөө зүтгэж байгааг юу гэж ойлгох вэ. Манай төрд тогтсон бичигдээгүй хуулиас үзэхэд дээрх эрхэм бүгд л дор бүрнээ асуудалтай, бүр зарим нь хууль шүүхийн байгууллагаар шалгуулаад явж байх юм. Тиймээс л эхний ээлжинд Ерөнхийлөгчийн суудлыг халхавч болгох санаархал агуулсан байхыг үгүйсгэхгүй. Нэгүгээр бол, АН-аас нэр дэвшигчид бүгд л дор бүрнээ тодорхой шалтгаан, зорилготойгоор төрийн тэргүүний суудалд санаархаж байгаа. Гэхдээ тэд эхлээд намынхаа нийт гишүүдийн итгэлийг хүлээсэн байх учиртай. Харин үүний тулд нэр дэвшигч бүр юу хийж байгаагаа таахад бэрх. Ягаад гэвэл АН-ынхан хэзээнээс нэгнээ дэгээдэж сурсан улс. Цагаа тулахаар тэдэнд үзэл бодол, үнэн чанар гээч зүйл үгүй болдгийг бид олон үйл явдлаас харсан. Хамгийн сүүлийн жишээ татахад л, АН-ын томоохон лидерүүдийн хагарал дээд цэгтээ хүрч, Н.Алтанхуягийн Засгийн газрыг үгээн хүйвалдаж унагасан удаатай. Тиймээс түүний хувьд энэ удаад өшөө авах ажиллагаа явуулахыг ч үгүйсгэхгүй. Харин хамгийн сүүлд нэр дэвшихээ зарласан Хууль зүйн сайд асан Д.Дорлигжав үнэхээр "сэтгэлийн дуудлагаар" гарч ирсэн үү эсвэл хэн нэгний түлхээсээр үү гэдэг нь анхаарал татаж байна. Болоогүй Ерөнхийлөгчийн засаглалтай болох нь зүйтэй хэмээн цаг минут бүрт уухуулж байгаа түүний цаад санааг таахад бэрх. Үнэндээ энэ эрхэм өөрийгөө ардчиллын алтан хараацайнуудын нэг гэдэг. Гэтэл тэдийгээс өдий хүртэл төрийн албанаас салаагүй, бүр хууль санаачлах хүртэл эрхтэй явсан атлаа ягаад өнөөдөр ямар ч албан тушаалгүй болсон хойноо нэг хүний засаглал тогтооё хэмээн чанга дуугарна вэ. Ийм засаглал чухам хэнд ашигтай вэ гэдэг асуулт урган гарч байна. Түүний тайлбарласнаар "Ерөнхийлөгчийн засаглалын давуу тал нь намын нөлөөлөлгүй болох" юм гэсэн. Гэтэл Үндсэн хуульда өөрчлөлт оруулахгүйгээр, парламентын тогтолцоогоо өөрчлөхгүйгээр ийм өөрчлөлтийг хийхэд бэрх. Үүнийг тэр өөрөө ч мэдэж байгаа. Нөгөө талаас Д.Дорлигжавын уг гарвалыг харвал Увс, Ховд талтай. Магадгүй АН "амьд үлдэх" ганц шаанс нь энэ учраас түүнийг нэр дэвшүүлэх, цаашлаад Монгол Улсыг нэг хүний удирдлагад оруулах зүйлийг хийлгэх сонирхолтой хүн цаана нь байж болох. Өөрөөр хэлбэл, улс төрийн ууган хүчин МАН үнэмлэхүй олонх болсон, АН бараг л арчигдахад хүрээд буй энэ нөхцөлд АН-аас Ерөнхийлөгч сонгогдож, улмаар Ерөнхийлөгчийн засаглалтай болчихвол бүхнийг гартаа оруулна гэж сэтгэсэн ч байж болно. Үгүй ядаж нэг хүний ноёрхол тогтоож, улс орноо ломбардад тавих гээгүй л бол ямар ч бэлтгэлгүйгээр засаглалын тогтолцоогоо өөрчилнө гэдэг цаг хугацааны асуудал. Эс бөгөөс ингэж ярьж ялгарах нь Д.Дорлигжавын хувьд нам дотор өрсөлдөгчдөөө зориулсан сум ч байж болох юм. Учир нь энэ намд түүнийг дэмжих нь бүү хэл, дэгээдэх, бүр гүтгэн гүжирдэх хүн мундахгүй олон бий. Хамгийн сүүлийн ганцхан жишээ татахад түүнийг Хууль зүйн сайдаар томилох гэж байхад өмнөх сайд Х.Тэмүүжин нь чадлаараа эсэргүүцсэнийг та бид мэднэ. Тухайн үед Д.Дорлигжав "Би энэ асуудлыг нухацтай шалгуулна. Намайг сайдад яригдаад УИХ-ын дарга санал тавиад эхлэхэд л Х.Тэмүүжин хүн явуулж энэ суудалд сууж болохгүй гэж шаардаж шахсан. Таньдаг найз нөхөд, хамаатан садан, гэр бүлийнхэн гээд олон ч хүнээр намайг ятгуулсан. Ятгаад дийлэхгүй болохоороо миний нэр хүндэд халдаж гүтгэлэг явуулсан" хэмээж байсан удаатай. Үүнээс үзэхэд АН-ынхан нэгнийхээ эсрэг юу ч хийж мэдэх улс. Д.Дорлигжавын хувьд намынхандаа энэ мэтээр шахуулж явсан түүх бий. Энэ удаад ч мөн шахуулахгүй гэх баталгаагүй. Тиймээс юуны өмнө бусдаас ялгарах зэвсгээ Ерөнхийлөгчийн засаглалтай болгож, намаа "амьд үлдээх" бодлого хэмээн тодорхойлж байж болох. Ямартай ч нам дотроо хөгжөөн дэмжигч цөөтэй, бүр дэгээдүүлчих гээд байдаг сайд асны дэвшүүлж буй бодлогыг ард түмэн дэмжих эсэх нь түн эргэлзээтэй. Учир нь тэр энэ удаад олон нийтийг маш гэнэн хүүхэд мэтээр төсөөлөн бодлогоо тодорх ойлоод байгаа. Өөрөөр хэлбэл, ямар ч суурь бэлтгэлгүйгээр улс орны засаглалын тогтолцоог өөрчилнө гэдэг нэг хүний хэлдэг, бас хийдэг ажил огт биш гэдгийг ард түмэн эрх биш гадарлахтайгаа болохоор түүнд итгэл хүлээлгэхэд бэрх л юм.

## ОНЦЛОХ ХУУДАС

Õýí íü õýí áý?

# Баянхонгорын **МӨНГӨЛӨГ** хоёр, **ЭРДЭМЛЭГ** нэг



Ч.ЧУЛУУН

"Хэн нь хэн бэ" булангийнхаа өмнөх дугаараас УИХ-ын гишүүдийн хэн нь хэн бэ, өмнө нь хэн байв, одоо хэн болов, юу хийж байна, сонгогчдын итгэл найдварыг дааж чадах төрийн түшээ мөн үү гэдгийг тольдон уншигчиддаа мэдээлж эхэлсэн билээ. Анхны зочдоор УИХ-ын сонгуулийн 1, 2, 3 дугаар тойрог буюу Архангай аймгаас сонгогдсон УИХ-ын гишүүдийн талаар онцолсон бол хоёр дахь дугаарт 4, 5, 6 дугаар тойрог болох Баян-Өлгий аймгаас сонгогдсон УИХ-ын гишүүн Х.Баделхан, Д.Мурат, Г.Солтан нарыг онцолсон. Харин энэ удаагийн дугаарт 7, 8, 9 дүгээр тойрог буюу Баянхонгор аймгаас сонгогдсон УИХ-ын гишүүн Г.Занданшатар, М.Билэгт, Л.Элдэв-Очир нарыг онцлон хүргэж байна. Дараагийн дугаартаа 10 дугаар тойрог буюу Булган аймгаас сонгогдож, УИХ-ын гишүүн болсон Ж.Бат-Эрдэнийг онцлох болно.

...Хамгийн сүүлд олимп, дэлхийн аварга шалгаруулах уралдаан тэмцээнд онцгой амжилт гаргасан үндэсний шигшээ багийн тамирчдад олгож буй төрийн урамшууллын мөнгийг хасах тухай ярьснаасаа болоод ихээхэн зэм хүртэж буй. Өөрөөр хэлбэл, Дэлхий дахинаараа спортод өндөр ач холбогдол өгч, хөрөнгө санхүүгийн онцгой дэмжлэгийг үзүүлж байгаа энэ цаг үед түүний гаргасан санаа байгаа олж тусаагүй...

### Шинэчлэгч

УИХ-ын 2012 оны сонгуулийн үр дүнд МАХН-ын шинэ залуу гишүүд "хувьсгалт" гэдэг үгээс татгалзсан нь чухамдаа Монголын улс төрд шинэ үзэгдэл болсон юм. Хоёр хүчний дунд хуваарилагддаг байсан эрх мэдэл гурван хүчний дунд шилжив. Үүнтэй зэрэгцээд намын өдөр тутмын гал тогоог барих хүний асуудал хөндөгдөх нь зүйн хэрэг. Намын Ерөнхий нарийн бичгийн даргын албан тушаал зөөлөн суудал биш. Гишүүддээ хүлээн зөвшөөрөгдөж чадах, эр зоригтой, гялалзуур, цаг хугацаа хийгээд нөхцөл байдлыг мэдрэх онцгой гэмээр чадвартай, хэлэх гэснээ хэлчихдэг, хийх гэснээ хийдэг хүн байх ёстой. Тийм хүн олж тавина гэдэг шинэчлэгсэд хийгээд бурхиудын хувьд амаргүй байсан нь ойлгомжтой. Намын Бага хурал хуралдахын өмнөх шөнө нам доторхи франциуд БОАЖ-ын сайд Б.Цогтбаатар, Гадаад хэргийн сайд Г.Занданшатар, Ж.Сүхбаатар нарыг өрсөлдүүлэхээр болсон ч шийдвэрлэх мөчид Г.Занданшатарт олонхийн саналаа өгснөөр тухайн үеийн МАН-ын дээрээсээ хоёр дахь хүн тодорсон түүхтэй. Занданшатарын хувьд шаггүй стратегич болох нь түүний улс төр дэх замнал нь харуулдаг. Тодруулж хэлбэл, тэрбээр улс төрийн томоохон албан тушаалыг хашиж үзсэн хойноо МАН-ын Ерөнхий нарийн бичгийн даргаар томилогдсон байдаг. Г.Занданшатар 1998 оны аравдугаар сарын гуравны өдөр МАХН-д элсэх өргөдлөө өгсөн гэж намтартаа өгүүлжээ. Цаг үе нь тэгж таарсан хэрэг үү эсвэл С.Зориг амиа алдсан явдал түүнийг ийм шийдэл гаргахад хүргэв үү гэдэг нь зөвхөн түүний хариулах зүйл. Намын клуб, залуучуудын байгууллагад ажиллаж байгаад 2004, 2008 УИХ-ын сонгуульд дараалан, 2016 онд дахин ялалт байгуулсан явдал түүний нэр хүндийг улс төрийн тавцанд ихээхэн өсгөсөн гэж хэлж болно. Тухайн үед Баянхонгор аймаг гурван мандаттай байсан юм. Тэрбээр 2005-2010 онд МАСЗХ-ны Удирдах зөвлөлийн гишүүн, дэд ерөнхийлөгч байсан бөгөөд 2010 онд тус холбоог өөрчлөн зохион байгуулах ажлыг шат дараатай хэрэгжүүлснээр "Нийгмийн Ардчилал-Монголын залуучуудын холбоо" болгон өөрчилж, шинэчлэлийн бодлогоо хэрэгжүүлж эхэлсэн байдаг. Парламентын гишүүнээр сонгогдсон өмнөх хоёр бүрэн эрхийн хугацаандаа тэрбээр УИХ-ын Төсвийн зарлагын дэд хорооны дарга, УИХ дахь МАН-ын бүлгийн дэд ахлагчаар ажиллаж, Татварын хууль, Бичил уурхайн тухай хууль, Авлигатай тэмцэх тухай хууль, Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль зэрэг 20 шахам хуулийн төслийг санаачилж, УИХ-ын 40 гаруй ажлын хэсгийн ахлагч болон гишүүнээр ажилласан бол энэ удаад нам жимхэн суугаа.

### Эрдэм шинжилгээний ажилтнаас Гадаад хэргийн сайд

Оюутны ширээний араас өндийсөн Г. Занданшатар эрдмийн ширээний ард суусан нь зах зээлийн коллежид (Одоо МУИС-ийн Бизнесийн сургууль) багш-эрдэм шинжилгээний ажилтнаар орсон явдал. Тэнд хэсэг ажиллаад Хөдөө аж ахуйн банкинд Гадаад тооцооны газрын эдийн засагч, гадаад тооцооны менежер, газрын захирал, зээл, мөнгөний бодлогын газрын захирал, Монгол банкны Сургалтын төвийн захирлаар томилогдож мөн ондоо Хөдөө аж ахуйн банкин дахь Монгол банкны бүрэн эрхт төлөөлөгч болов. Тэрбээр ажил хүлээж авсан даруйд банкиндаа бүтцийн өөрчлөлт хийх төлөвлөгөөг боловсруулж, банкийг сэргээн босгох, дахин хөрөнгөжүүлэх үйл ажиллагааг удирдан ажилласнаар тус банк төрийн өмчид шилжиж, эдийн засгийн үр ашигтай санхүүгийн байгууллага болж чадсан гэж эдүгээ ХААН банк эдийн засгийн хувьд үр ашигтай ажиллах үндэс суурийг нь тавьсан хэмээн банкны салбарынхан дүгнэдэг. Харин тэр эл амжилтынхаа дараа 2003 онд Хөдөө аж ахуйн дэд сайдаар томилогдсон байдаг. Яамны сайд нь Д.Насанжаргал байв. Түүний үед Атрын III аяныг өрнүүлэхээр болж Засгийн газар УИХ-д санал хүргүүлсэн юм. Занданшатарын нэр хүнд ч өссөөр. Гадаад харилцааны сайд Сү.Батболд Монгол улсын Ерөнхий сайд болсноор Г.Занданшатар 2009 оны арваннэгдүгээр сард Гадаад харилцааны сайдаар томилогдов. Тэрбээр сайдаар ажилласан хугацаандаа Монгол Улсын "Гадаад бодлогын үзэл баримтлал" баримт бичгийг боловсруулж, батлуулсан явдал түүний нэр хүндийг мөн л өргөж, 2011 онд Монгол улс Ардчилсан орнуудын хамтын нийгэмлэгийг хоёр жил даргалах хүндтэй үүргийг түүнд өгсөн байна. Ер нь тэрбээр Монгол Улсын гадаад харилцаа төдийгүй энэ салбарт ажиллагсдын хууль эрх зүйн орчинд анхаарал хандуулж, Дипломат ажилтны сахилгын тусгай дүрмийг шинэчилж, сахилга хариуцлага, ёс зүй алдсан дипломат ажилтныг ажлаас халах хүртэл арга хэмжээ авахаар болсон юм. Эл арга хэмжээ эдүгээ ч хүчин төгөлдөр хэрэгжиж буй.

### Стэнфордын их сургуулийн ахлах зөвлөх

Тэрбээр улс төрөөс завсарлага авсан дөрвөн жилд хаагуур явж, юу хийсэн тухайгаа "Улс төрд удаан хутгалдлаа, цаашдаа ямар нэгэн байдлаар вакуум орчинд орох нь гарцаагүй. Тиймээс Монголын нийгэм, төр засгийн байдлыг хөндлөнгөөс нэг ажиглаад судалгаа хийгээд үзье гэж бодсон юм. Ер нь Америкийн болоод дэлхийн ардчилал хөгжсөн орнуудын туршлагаас харахад, улс төрд хэтэрхий удаан ажилласан хүн тодорхой хугацааны дараа түр чөлөө авч олон улсын судалгааны төвүүдэд очиж ажилладаг байдал анзаарагддаг. Ялангуяа над шиг гадаад харилцааны чиглэлээр ажиллаж байсан хүмүүс хуримтлуулсан туршлагаа мэдлэгтэй хослуулах нь чухал гэдгийг мэдэрсэн" хэмээн тайлбарласан. Тодруулбал, АНУ-ын Стэнфордын их сургуулийн Зөвлөлдөх ардчиллын хүрээлэнд судлаачаар ажиллаж, Монгол зэрэг хөгжиж буй орнуудын ардчилсан хөгжлийн загварыг хөгжингүй орнуудын ардчилалтай харьцуулан судласан байдаг.

### Цэцэн Ярославын одонт гишүүн

УИХ-ын гишүүн Г.Занданшатар 1970 оны гуравдугаар сарын 8-нд төржээ. Нийслэлийн арван жилийн 77 дугаар сургуулийг 1987 онд, ЗХУ-ын Эрхүү хотын Улс ардын аж ахуйн дээд сургуулийг 1992 онд (Одоо Байгалийн Улсын их сургууль) элсэж, санхүү-зээлийн эдийн засагч мэргэжлээр тус тус төгссөн байна. Дашрамд сонирхуулахад, Г.Занданшатар гэх нэрийг түүнд эх барьж авсан эмч Ёндонцоо нь хайрласан аж. Гурван настайдаа шатар тоглож сурсан тэрбээр орсон гарсан хэнийг ч болов шатар тоглоё хэмээн гуйдаг хүү байжээ. Дэлхийн шатрын холбооны ерөнхийлөгч К.Илюмжинов, Болгарын шатарчин, дэлхийн 10 удаагийн аварга А.Стефанова нараас гадна Монголын их мастеруудтай өрөг наадуулсан цорын ганц монгол хүн. Мөн Украины төрийн дээд шагнал Цэцэн Ярославын одонг Монголоос хүртсэн хүн ердөө хоёр байдгийн нэг нь Г.Занданшатар, нөгөө нь Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж аж.

### Хонгор нутгийг бэлгэнд умбуулагч Л.Элдэв-Очир

"MCS"- группийн үүсгэн байгуулагчдын нэг, томоохон хувьцаа эзэмшигч Л.Элдэв-Очирын эдүгээ УИХ-д хонгор нутгийн иргэд сонгогчдыг төлөөлөн сууж буй. Тэрбээр УИХ-ын гишүүний зөөлөн сэнтийд залрахыг эртнээс мөрөөдсөн нэгэн. УИХ-ын 2012 оны ээлжит сонгууль болохоос хоёр жилийн өмнө аймагтаа суурьшин аймгийнхаа МАН-ын даргын албыг хашиж байлаа. Гэвч асуудал түүний санаснаар болоогүй. Гадаад Харилцааны Сайд Г.Занданшатар тойрогтоо эзэн суух үүднээс түүнийг Монгол Улсаас Канад улсад суух Элчин сайдын зөвлөхөөр томилон, дэвшүүлэнхэн зайлуулсан удаатай. Түүнийг нутаг нугийнхандаа гарын бэлэг, хурдан морийг баруун солгойгүй тараасны буянд УИХ-д гарч ирсэн хэмээдэг ч энэ талаар хэрүүл болж байна гэж дуулдаагүй. Харин УИХ-ын хөрөнгөлөг, мөнгөлөг гишүүдийн төвийн жигүүрийн манлай тэрбээр өнгөрсөн жилийг саарал ордон хийгээд УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдааны танхимын үйл ажиллагаатай танилцсаар барсан нь гарцаагүй үнэн. Ингэж жил илүүтэй ажин түжин суусны эцэст Төрийн ордон, улс төрийн хүрээнийхэн, бүлгийнхээ гишүүдийг цочтол "мэдэгдэл" хийж, сүйдийг нь холих шахсан. Тэрбээр "...Тавантолгойн гэрээг явуулах лобби бүлэг байгуулъя. Зардал, мөнгөө босго гэж хүмүүс над дээр орж ирлээ" гэж мэдэгдсэн байна. Л.Элдэв-Очирын энэхүү гэнэтийн гэмээр мэдэгдэлд цочирдсон гишүүд "... Хэн тэгсэн, ямар гишүүд тан дээр орсон юм. Нэрийг нь хэл" хэмээн шаардахад мань гишүүн "...Манай намын гишүүд биш" гэж. Гишүүд "...Тэгвэл АН-ын гишүүд гэсэн үг үү" хэмээн ээрч түүнийг сүрхий сандаргаад авч. Эрхэм УИХ-ын гишүүн одоогоор иймэрхүү л паянтай саарал ордонд аж төрж буй. Л.Элдэв-Очир гишүүн 1986-1991 онд Эрчим хүчний барилга угсралтын конторт монтёр, мастер, ерөнхий инженер, дарга, 1992-1994 онд "Мон Стар" компанийн захирал, 1996-1998 онд "М-Си-Эс Интернэйшнл" компанид дэд захирал, 1998-2003 онд "Спирт Бал Бурам" компанийн ерөнхий захирал, 2004-2008 онд "Зүүнхараа Трейд" компанийн гүйцэтгэх захирал, 2009-2012 онд "М-Си-Эс Групп"-ийн дэд ерөнхийлөгч, 2012-2013 онд Монгол Улсаас Канад Улсад суугаа Элчин сайдын яамны Элчин зөвлөх, 2013-2016 онд "М-Си-Эс Групп"-ийн дэд ерөнхийлөгчөөр тус тус ажилласан.

### "Ачлал"-ын М. Билэгт

Энэ хатагтай сүүлийн үед УИХ- ын чуулганы нэгдсэн хуралдааны танхим болон байнгын хороодын хуралдаан дээр дуугарах гэж оролдож байгаа нь сайн хэдий ч буруу дуугарч, дуугарснаасаа эс юм болдог. Хамгийн сүүлд олимп, дэлхийн аварга шалгаруулах уралдаан тэмцээнд онцгой амжилт гаргасан үндэсний шигшээ багийн тамирчдад олгож буй төрийн урамшууллын мөнгийг хасах тухай ярьснаасаа болоод ихээхэн зэм хүртэж буй. Өөрөөр хэлбэл, Дэлхий дахинаараа спортод өндөр ач холбогдол өгч, хөрөнгө санхүүгийн онцгой дэмжлэгийг үзүүлж байгаа энэ цаг үед түүний гаргасан санаа байгаа олж тусаагүй. Гэхдээ хөөрхий тамирчдаасаа харамласан төсвийн хэдэн төгрөгөө Баянхонгорынхондоо өгөх гэж тийн зүтгэснийг ангийнхан нь ойлгоогүй байж ч мэднэ. Ерөөсөө М.Билэгт гишүүн улс төрд гэнэт орж ирсэн эмэгтэй. Тодруулбал, "Ачлал" их дэлгүүрийн түрээс түүнд ийм амжилтыг бэлэглэсэн хэрэг. УИХ-ын гишүүн М.Билэгт гэвэл ард түмэн "тийм хүн байдаг билүү" гэж мэднэ. Харин III.IY хорооллын Билэгт гэвэл нийслэлийнхэн андахгүй байх. Боловсрол энэ тэрийн тухайд бусдаас онцгойрох юмгүй. Хонгор нутгийн сайн сайхны төлөө юу хийж бүтээсэн нь одоогоор мэдэгдсэн зүйл байхгүй. Ирэх гурван жилд хийж бүтээнэ гэдэгт нь найдаж л суухаас. М.Билэгт нэр цэвэр улстөрчдийн тоонд багтдаггүй. Татвараас зайлсхийсэн хэрэгт холбогдоод амжсан. Нийслэлийн Татварын газрынхан "Ачлалтрейд" компанид хийсэн шалгалтаар 2013 оны нэгдүгээр сарын 01-нээс 2014 оны арванхоёрдугаар сарын 31-ний өдрийн албан татвар, төлөлтийн байдалд шалгалт хийж 4.4 тэрбумын нөхөн татвар, 3.1 тэрбумын торгууль, 1.9 тэрбумын алданги гээд нийт 9.5 тэрбумын төлбөрийг ногдуулахад тэрбээр актыг хүлээн зөвшөөрч 4.4 тэрбумын төгрөгийн татвар төлж, улсыг хохиролгүй болгосон гэдэг.

# ОРОН НУТАГ

## Аймгаас мэдээлж байна

ДОРНОГОВЬ АЙМАГ

### “Нээлттэй хаалганы өдөрлөг” болно

Дорноговь аймгийн Засаг даргын Тамгын газраас нутгийн захиргааны байгууллагын явуулж буй үйл ажиллагааг иргэд олон нийтэд сурталчлах, тайлбарлан таниулах, санал хүсэлтийг сонсох зорилгоор энэ сарын 27-ны өдөр буюу өнөөдөр аймгийн төв талбайд “Нээлттэй хаалганы өдөрлөг”-ийг зохион байгуулах гэж байна. “Нээлттэй хаалганы өдөрлөг”-т аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, харьяа газар, холбогдох төрийн байгууллагууд хамрагдах юм байна. Мөн өдөрлөгийн үеэр Сайншанд суманд нарны цахилгаан станц барих “Дезерт солар пауэр вуан” ХХК аймгийн Засаг даргатай байгуулсан нийгмийн хариуцлагын гэрээний дагуу орон нутгийн иргэдээс бүтээн байгуулалтын ажилд орон нутгаас авах боломжтой хүний нөөцөө бэлтгэх зорилгоор нээлттэй ажлын байранд бүртгэл хийхээс гадна нийгмийн халамж шаардлагатай таван өрхөд гэр олгож, дэмжлэг үзүүлэх аж.

ОРХОН АЙМАГ

### Хөдөлмөрийн өдөрлөг зохион байгуулав



Монгол Улсын Засгийн газар, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас болон аймаг орон нутгийн зүгээс иргэдийг хөдөлмөрийн зах зээлд эрэлттэй мэргэжил эзэмшүүлэх, ажлын байраар хангах, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих чиглэлээр нэлээд ажил хийж байгаа. Тухайлбал, 2017 оны нэгдүгээр сарын 27-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор батлагдсан “Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох хөтөлбөр”, “Ажлын байрыг дэмжих хөтөлбөр”, “Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр”, ” Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”, “Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-үүд ч Орхон аймагт хэрэгжиж эхлээд байгаа юм. Тэгвэл энэ хүрээнд тус аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар, Хангайн бүсийн арга зүйн төв, Орхон аймаг дахь МСҮТ-үүдтэй хамтран Амарын талбай дээр “Хөдөлмөрийн өдөрлөг” зохион байгууллаа. “Хөдөлмөрийн өдөрлөг”-ийн нээлтийн ажиллагаанд Орхон аймгийн Засаг даргын орлогч А.Түвшинжаргал, Хот байгуулалт, дэд бүтэцийн асуудал хариуцсан орлогч С.Батжаргал, ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга А.Бумансор, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга Ц.Баяржаргал нарын албаны хүмүүс оролцож, үг хэллээ. Мөн өдөрлөгийн үеэр МСҮТ-үүдийн оюутнуудын хийсэн бүтээлийн үзэсгэлэн худалдаа гарснаас гадна элсэгчдээ бүртгэсэн юм. Мөн ажил идэвхитэй хайж байгаа иргэдийг ажлын байранд зуучлах зэрэг үйлчилгээг иргэдэд үзүүлэв.

### Хувийн хэвшлийн эмнэлгүүдтэй гурвалсан гэрээ байгууллаа

Орхон аймгийн Бүсийн оношлогоо, эмчилгээний төвийн амбулаторийн үзлэг болон, хэвтэн эмчлүүлэгчдийн тоо сүүлийн жилүүдэд тасралтгүй өсч, ачааллаа даахгүйд хүрээд байна. Орхон аймгийн төр захиргааны зүгээс “Хүний хөгжилд” чиглэсэн бодлогын үйл ажиллагаа явуулж байгаа. Үүний гол ухагдахуун нь “эрүүл иргэн” юм. Иргэдийнхээ эрүүл мэндийг хамгаалах, эрүүл мэндийн тусламж үйлчилгээг чанаржуулахын тулд өнөөдөр Орхон аймгийн Засаг дарга, Эрүүл мэндийн газрын зүгээс ортой хувийн хэвшлийн эмнэлгүүдтэй гурвалсан гэрээг байгууллаа. Энэ нь БОЭТ-ийн ачааллыг багасгахад дөхөмтэй алхам болж байна. Өөрөөр хэлбэл иргэд БОЭТ-д хэвтэн эмчлүүлэхэд олон хоногоор ор хүлээж хугацаа алддаг байдлыг багасгахын тулд Нийгмийн даатгалын сангаас хувийн хэвшлийн эмнэлгүүдэд санхүүжилт олгож, иргэд хувийн хэвшлийн эмнэлэгт хэвтэн эмчлүүлэх боломж нээгдэж байна. Хувийн хэвшлийн 11 эмнэлэг, “Эрдэнэтийн эрүүл иргэн” төрийн бус байгууллагатай орон нутгийн төр засгийн зүгээс хамтран ажиллах гэрээг ийнхүү үзэглэлээ. Үүний үр дүнд иргэд эмнэлгийн тусламж үйлчилгээг чанар, хүртээмжтэй авах боломж бүрдэж байна.

БУЛГАН АЙМАГ

### Нэгжээс авах ургацын хэмжээг нэмэгдүүлэхэд анхаарна

Булган аймгийн тариалан эрхлэгчдийн зөвлөгөөн боллоо. Зөвлөгөөнд аймгийн Засаг дарга, Засаг даргын зөвлөх, Ургамал газар тариалангийн хүрээлэнгийн төлөөлөгчид оролцов. Мөн Тариалан эрхлэлтийг дэмжих сан, ХААН банк зэрэг байгууллагууд тариаланчидтай холбоотой мэдээллийг хүргэжээ. Энэ онд тус аймгийн тариаланчид 43 мянган тариалалт хийхээр бэлтгэл ажлаа хангаад байгаа бөгөөд аймаг газар тариалангийн талаар бодлогын баримт бичгээ боловсруулсан төдийгүй га талбайг нэмэх бус нэгжээс авах ургацын хэмжээг нэмэгдүүлэх бодлого барин ажиллаж байгаа аж. Энэ ч үүднээс ОХУ-ын Красноярск мужтай хамтын ажиллагаа тогтоон ажиллаж байгаа гэнэ. Зөвлөгөөнөөс тариаланчдын хувьд төрөөс баримталж байгаа журам, хууль, аймгаас гаргасан захирамжийн хэрэгжилт газар дээрээ биеллээ олохгүй байгааг хэлж байсан юм. Малчид мал бүхий иргэд тариалангийн талбайг заасан хугацаанд чөлөөлөхгүй байх, тараиланчдын барьж босгосон хашааг сүйтгэх, тариалангийн талбайд хариулгагүй мал орох зэрэг зөрчил арилахгүй байсаар байгааг ч тэд онцолсон. Түүнчлэн тус аймгийн хэмжээнд 80 аж ахуйн нэгж, 747 өрхийн тариаланч 89200 га талбайд тариалангийн талбай эзэмшиж, жилдээ 37 мянган га-д үр тариа, 1000 га-д төмс, хүнсний ногоо тариалж байна.

АЛБАНЫ ХҮНИЙ ҮГ



## Д.Эрдэнэбаатар: МАНАЙ ТҮВШНИЙХ АТАЛ ХОЁРДУГААР

Ч.ЧУЛУУН

*Архангай аймаг хөгжлийнхөө гарцыг хамгийн зөв хувилбараар тодорхойлсон нь Цэцэрлэг хотын бүтээн байгуулалт, хөгжил дэвшил хэлээд өгөх аж. Зөв менежмент гэж үүнийг л хэлэх байх. Аймгаа хотоо өнгөтэй өөдтэй байлгахын төлөө хувь хүнээс өгсүүлээд байгууллага, аж ахуйн нэгжүүд ч зүтгэсэн нь илт. Тэдэн дунд Онцгой байдлын газрын шинэхэн барилга аймгийнхаа хөгжил дэвшил дээр өнгө нэмэн, орсон гарсан хэн бүхний харааг хамгийн түрүүнд булаах юм гээч. Ингээд Архангай аймаг дахь Онцгой байдлын газрын дарга, дэд хурандаа Эрдэнэбаатартай албан өрөөнд нь ярилцлаа. Ажлаа мэддэг хүн шийдвэр гаргахдаа ч алддаггүй юм байна гэдгийг хэдхэн үгийн солионд мэдэрснээ нуух юун.*

**-Засаг даргатай уулзахад гэнэт орсон их хэмжээний цас, шар усны үерийг гарз хохирхол багатайгаар давж гарсны цаана Архангай аймаг дахь Онцгой байдлын газрын үйл ажиллагаатай салшгүй холбоотой хэмээн онцлон тэмдэглэсэн?**

-Юун түрүүнд хамт олны минь хичээл зүтгэлийн үр дүн гэж хэлэх байна. Манай хамт олон аймгийн Засаг даргын 2016-2017 оны өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах тухай захирамжийн дагуу төлөвлөгөө боловсруулж, түүнийгээ шат шатандаа хэрэгжүүлж, шуурхай бүлэг байгуулан ажиллаж ирлээ. Төлөвлөгөөний хэрэгжилт өнөөдрийн байдлаар 80 гаруй хувьтай яваа. Аймаг өөрөө ч өвөлжилт, хаваржилтад онцгой ач холбогдол өгч, шаардагдах хөрөнгө мөнгийг цаг алдалгүй шийдвэрлэж ирсний үр дүнд 70 гаруй тонн өвс, 36 тонн тэжээл бэлтгэж нөөцөлсөн. Тэгээд ч харьцангуй сайхан өвөл болж өнгөрлөө гэж дүгнэж болно. Хэдийгээр аймгийн нийт нутгийн 90 орчим хувь нь цасан бүрхүүлтэй, 5-8 суманд өвөлжилт хүндэрсэн ч Улсын онцгой комиссын дэмжлэгтэйгээр асуудлыг тухай бүрт нь шийдэж чадсан. Манай шуурхай бүлэг аймгийн Засаг даргын орлогчоор ахлуулсан ажлын хэсэг өвөлжилт хүндэрсэн сумдад тун сайн ажилласан. Сая орсон их цасны үеэр ч бид өндөржүүлсэн бэлэн байдалд ажиллаж, 380 тонн өвсийг хүргэх ёстой газарт нь цаг алдалгүй, амжилттай хүргэсэн. Нөгөөтэйгүүр, өвөлжилтийн хүндрэл , гэнэт орсон их цаснаас гадна малын цэцэг өвчин Өгийн нуур, Хашаат суманд гарч манай шуурхай бүлэг тэнд гурван сар ажилласан. Шаардлагатай бүхий л арга хэмжээг авсны үр дүнд цэцэг өвчний тархалтыг газар авахуулалгүйгээр зогсоож чадсан.

**-Хуурайшилт, түймэр, шар усны үер та бүхний хүчийг ихээхэн сорьдог. Үүний дараа гол устай холбоотой асуудал гардаг. Хүн хүчний хувьд танай газар хангалттай юу?**

-Манай Онцгой байдлын газар эрэн хайх, аврах салбар, гал түймэр унтраах 51 дүгээр анги, улсын нөөцийн салбар гэсэн гурван нэгжтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна. Архангай аймаг 57.3 мянган хавтгай км газар нутагтайн дээр 19 сумтай. Тэгэхээр манай газар 19 суманд авран хамгаалах, эрэн хайх түймэр унтраах үйлчилгээг үзүүлдэг. Дээр нь шаардлагатай тохиолдолд хүмүүнлэгийн тусламж үзүүлдэг. Зэрэг зэрэг дуудлага ирэхгүй бол байгаа хүч бололцоогоо л ашиглана шүү дээ. Сумдад салбар нэгж байхгүй учир өндөр ачаалал дор үүрэг гүйцэтгэдэг гэж хэлж болно. Алслагдсан сумаас дуудлага хүлээж авлаа гэхэд газрын бартаанаас шалтгаалаад 4-5 цагийн дараа үйлчилгээ үзүүлэх жишээний. Тиймээс аймгийнхаа удирдлагуудад хандаж, хүн ам ихээр төвлөрсөн сумдад авран хамгаалах ангийг шинээр нэмж байгуулах санал хүргүүлсэн. Тариат сумын төв дээр аврах, гал унтраах анги бий болсон тохиолдолд зүүн талын сумдад цаг алдалгүй үйлчилгээ үзүүлэх боломж нээгдэх жишээний. Тэгээд ч Тариат сум гол, нуур ихтэй, зуны улиралд гадна дотны жуулчид тасардаггүй. Сүүлийн жилүүдэд нууранд осолдсон хүний тоо нэмэгдсээр байгаа. Жил өнжихгүй осол гарч байна. Энэ өвөл гэхэд мөс цөмөрч дээгүүр нь явж байсан машин осолдсон. Хүний амь нас ч эрсэдсэн. Одоогийн манай газрын бүтэц, бие бүрэлдэхүүн, гал түймэр унтраах, аврах ангийн зэрэглэл гуравдугаар түвшнийх. Гэтэл хоёрдугаар зэргийн анги гэж үнэлэгддэг. Тиймээс хүн хүчээ нэмэх шаардлага тулгараад байна. Бүхэл бүтэн тасгийг шинээр бий болгох учиртай. Хөдөлмөрийн хуулиар дөрвөн ээлжийн зохион байгуулалттайгаар ажиллах ёстой атал өнөөдөр 2-3 ээлжээр ажилладаг. Машин техник, хэрэгслийн хувьд харьцангуй сайжирч, парк шинэчлэлтийг жил бүр тодорхой түвшинд хийсээр ирсэн. Хамгийн сүүлд гал унтраах машиныг орон нутгийн төсвөөр худалдаж авсан. Онцгой байдлын ерөнхий газраас шуурхай албаны зориулалт бүхий автомашиныг өгсөн. Өнгөрсөн жил 2.9 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар гал түймэр унтраах хоёрдугаар зэргийн ангийн барилгыг шинээр барьж, ашиглалтад орууллаа. Барилга маань найман автомашины дулаан гражтай, дээд давхартаа найман айлын орон сууцтай. Тэндээ албан хаагчдаа оруулсан.

**-Монголчууд болоод өнгөрсөнхойноньамаабарьдаг зантай. Авран хамгаалах үйл ажиллагаа явуулахаас илүүтэй урьдчилан сэргийлэх нь чухал бус уу. Урьдчилан сэргийлэх сургалтууд төлөвлөгөөт ажлын хэдэн хувийг эзэлдэг вэ. Ийм чиг үүрэг байна уу?**

-Байлгүй яах вэ. Бидний ажлын нэгээхэн хэсэг урьдчилан сэргийлэх, түүнтэй холбоотой сургалт арга хэмжээ шүү дээ. Авран хамгалаахаасаа өмнө урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулж, энэ хүрээнд сургалтуудыг явуулъя гээд онцгой байдлынхаа бүтцэд урьдчилан сэргийлэх тасгийг шинээр бий болгосон. Манай газрын орлогч дарга ахалдаг юм. Сургалт, сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн ч бий. Аж ахуйн нэгж байгууллагуудад урьдчилан сэргийлэх ажлыг жилийн турш тасралтгүйгээр зохион байгуулсаар ирсэн. Энэ жил ч зохион байгуулна. Манай албан тушаалтнууд бүгд хариуцсан гудамж, хороололтой. Хуваарьт өдрөө хариуцсан гудамж, хорооллоороо явж иргэдийн дунд сурталчилгаа, мэдээллийн арга хэмжээг зохион байгуулдаг. Мөн гамшгаас хамгаалах хоёр улсын байцаагчтай. Байцаагч нар маань хариуцсан байгууллагуудаараа явж, хяналт тавихаас гадна урьдчилан сэргийлэх ажлыг хэрхэн зохион байгуулах талаар зөвлөгөө өгдөг. Аймгийн Засаг дарга ч биднийг дэмжиж, жил бүр гурван суманд гамшгаас хамгаалах сургалт, сургууль арга хэмжээг зохион байгуулдаг. Саяхан Эрдэнэмандал суманд гамшгаас хамгаалах иж бүрэн сургууль арга хэмжээг зохион байгуулсан. Энэ долоо хоногт хоёр суманд зохион байгуулах хуваартай. Сургуулилтын гол зорилго нь иргэдэд мэдээлэл өгөхөөс гадна гамшгаас хамгаалах боловсрол олгох чадавхжуулах, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх явдал юм. Энэ удаад орон нутгийн удирдлагууд шинээр томилогдсон учраас тэднийг чадавхижуулах зорилго дор зохион байгуулж буй.

**-Онцгой байдлын алба дайчдаасаа хурд, хүч, авхаалж самбаа, түргэн сэтгэх зэрэг олон чадварыг шаарддаг?**

-Онцгой байдлын албан хаагчийг сургаж, дадлагажуулах нь хамгийн чухал ажил. Онцгой байдлын ерөнхий газраас бодлогоор 2017 оныг сургалтын жил болгон зарлаж, жилийн хугацаанд хэрэгжүүлэх хөтөлбөрийг төлөвлөгөөний хамт ирүүлсэн байгаа. Сургалтууд ч аврагч, гал сөнөөгч, усчин аврагч, офицерийн, албан хаагчдын гээд шат шатанд явагддаг. Мөн олон улсын сургалтад хамруулах нь ч бий. Онол, практикийн сургалтыг маш сайн явуулснаар аврагч нарын мэргэжлийн ур чадвар сайжирна. Өөрийгөө төдийгүй


## ТЕНДЕРИЙН УРИЛГА

**Огноо:** 2017.04.27
**Тендер шалгаруулалтын нэр:** “Нью Дарьганга” ОНӨҮГ-ын материаллаг баазыг бэхжүүлэх, тоног төхөөрөмж / Тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, автомашин/ нийлүүлэх,
**Тендер шалгаруулалтын дугаар:** 2017-Б021

[Сүхбаатар аймгийн засаг даргын тамгын газар] эрх бүхий тендерт оролцогчдоос [“Нью Дарьганга” ОНӨҮГ-ын материаллаг баазыг бэхжүүлэх, тоног төхөөрөмж /Тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, автомашин/ бараа нийлүүлэх ]–г нийлүүлэх тухай 3 багц бүхий битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Багц-1 Телевиз, хөгжим, компьютер, техник, тоног төхөөрөмж түүний дагалдах хэрэгсэл нийлүүлэх

Багц-2 Гал тогооны тоног төхөөрөмж нийлүүлэх

Багц-3 Бага оврын зорчигч тээврийн автомашин нийлүүлэх

Уг тендер нь цахим тендер шалгаруулалтын журмаар зохион байгуулагдаж байгаа тул тендерт оролцогч нь Цахим худалдан авах ажиллагааны систем (www.tender.gov.mn)-д хандаж тендерийн бичиг баримтыг үнэ төлбөргүй татаж авна уу.

Тендерт оролцогч нь тендер илгээхийн өмнө 50000 /тавин мянган/ төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байх ёстой.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн [45] хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.

**Үүнд:**

**Борлуулалтын хэмжээ:** Сүүлийн 3 жилийн буюу 2014, 2015, 2016 борлуулалтын орлогын дундаж нь санал болгож буй үнийн дүнгийн 70 хувиас багагүй байна.

**Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ:** [Санал болгож буй үнийн дүнгийн 50 хувиас багагүй байна]

**Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо:** Сүүлийн 3 жилийн буюу 2014, 2015,2016

**Сүүлийн гурван жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын өртөг:** Сүүлийн 3 жилийн буюу 2014, 2015, 2016 оны ижил төстэй /санал болгож буй үнийн дүнгийн 50%-аас багагүй байна. /Ижил төстэй ажил гэдэгт тухайн оролцож буй багцад заагдсан бараа, тоног төхөөрөмжийг нийлүүлсэн байна/

Тендерийн хамт тендерийн батлагааг багц тус бүр дээр ирүүлнэ.

Багц-1 274,620 төгрөгийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

Багц-2 544,020 төгрөгийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

Багц-3 440,000 төгрөгийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

Аль нэг багцад оролцож буй компани нь тухайн багцад хамаарах чиглэлээр үйл ажиллагаа явуулах эрхтэй байна.

Тендерийг [2017 оны 05 сарын 29-ны өдрийн 14 цаг 00 минут]–аас өмнө доорх хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг [2017 оны 05 сарын 29]-ны өдрийн, [14:30] -т нээнэ.

**Дотоодын давуу эрх тооцохгүй.**

**Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхгүй,**

*Уг тендер нь цахим тендер шалгаруулалтын журмаар зохион байгуулагдаж байгаа тул тендерт оролцогч нь Цахим худалдан авах ажиллагааны систем (www.tender.gov.mn)-д өөрийн аж ахуйн нэгжийн цахим гарын үсгээр нэвтрэн орж тендерийн материалаа цахим хэлбэрээр ирүүлнэ. (Ахлах мэргэжилтэн Ч.Батболд, Утас:96510404, 70518123)*

**Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно. Сүхбаатар аймгийн, Баруун-Урт сум Орон нутгийн өмчийн газар Нутгийн удирдлагын ордон 3 давхарт 306 тоот өрөө, Утас: 70518123, 96510404**

ОРОН НУТАГ

өрөөлийг аврах чадвартай болох нь юу юунаас чухал шүү дээ. Усчин аврагчдын сургалтыг бодлогоор өвөл, зуны улиралд дадлагаар нууран дээр бодит нөхцөлд зохион байгуулдаг. Шинээр орж ирж байгаа албан хаагчдыг практикаар л дадлагажуулж авахгүй бол шууд аврагч мэргэжлийн эзэн болно гэж найдах хэрэггүй. Маш их цаг хугацаа шаарддаг. Онцгой байдлын ахлагчийн сургуулийг төгссөн албан хаагчдыг аль болох томилохыг хичээдэг.

**-ОБЕГ-ын хэмжээнд уламжлал болгон зохион байгуулагддаг Гал унтраах техникийн олон төрөлт спортын бүсийн аварга шалгаруулах тэмцээнийг Архангай аймаг, та бүхэн зохион байгуулахаар болсон байна?**

-Гал унтраах техникийн олон төрөлт спорт нь Онцгой байдлын албан хаагчдын тархалт гэж төрөл байдаг. Өнгөрсөн жилийн бүсийн аварга шалгаруулах тэмцээнд манай хамт олон байлдааны тархалтын төрөлд амжилттай оролцон хүрэл медаль хүртсэн. Бүсийнхээ аваргын тэмцээнийг орон нутагтаа авч байгаагийн хувьд өндөр ач холбогдол өгч, амжилт гаргана гэдэгтээ итгэлтэй байгаа шүү.

**-Санхүү, хөрөнгө оруулалтын байдал өдөр тутмын үйл ажиллагааг тань хангахад хангалттай байж чаддаг уу?**

-Төсөв, санхүүгийн хувьд төсвийн хэмнэлт гэдгээр жилээс жилд хасагдсаар байгаа. Үнэнийг хэлэхэд, албан хаагчдын хоолны зардал төдийд зарцуулаад дуусдаг юм. Улсын эдийн засаг ямар байгаа билээ. Бид нөхцөл байдалд зохицон амьдарч, үйл ажиллагаагаа явуулсаар ирсэн. Их хэмжээний гамшиг осол гарсан үед аймгийн ЗДТГ-аас дэмжлэг авч аймгийн дээр тэдэндээ ямар зөвлөгөө өгдөг вэ?**

-Жилээс жилд аюул, гамшгийн төрөл давтамж нэмэгдэх болсон. Өмнө нь гарч байгаагүй осол аваарууд их гарч байна. Энэ энэ байгууллага, хамт олноосоо эхэлж байлаа. Гал сөнөөгчөөр анх ажилд орж удалгүй гал унтраах машины жолооч болсон. Дараа нь сургуульд явсан. Тэгээд 2009 онд албаны

> ...Байгууллагаа өнгөтэй, өөдтэй авч явья гэсэн үүднээс газраа өөрийн гэсэн орон байртай болголоо. Өмнө нь манайх цагдаагийн газрын хашаан дотор үйл ажиллагаагаа явуулдаг байсан юм. Шинэ барилгатай болох зорилго тавьж, арав гаруй жил хөөцөлдөж байж сая нэг юм өөрийн гэх байр савтай болсон. Онцгой байдлын ерөнхий газар маань ч дэмжиж, Засгийн газар болон холбогдох байгууллуудад хандан хүсэлт гарган, албан бичиг явуулах зэргээр их тус болсон...

газрын асуудал байсан. Аймгийн төвийн "А" зэрэглэл дотор газар олдохгүй байсны улмаас Булган хангайн хорооллын нутаг дэвсгэрт барилгынхаа суурийг тавьсан Тэр үед энэ хавьд нэг ч барилга баригдаагүй байсан. Эдүгээ манайхыг дагаад хамгийн хөгжил сайтай хороолол болсныг та бүхэн анзаарсан байх. Миний хувьд эхлүүлсэн ажлынхаа үр дүнг харах гэж чармайх аваас бүтэхгүй зүйл гэж байдаггүйг эндээс мэдэж авсан. Би харьцангуй залуу хүн шүү дээ. Энэ бол миний ажил, амьдралдаа буй болгосон хамгийн том бүтээн байгуулалт.

**-Танайд орон гэргүй, айлын хашаа байшин түрээсэлж амьдардаг байгаа алба хаагч байна уу?**

-Байгаа. Шинээр томилогдож ирсэн албан хаагчдынхаа нийгмийн асуудлыг түрээсийн орон сууцаар л шийдэж ирлээ. Гэхдээ сая манай найман улам чанаржуулах, техник хэрэгслээ шинэчлэх нь бидний нэн тэргүүний зорилго. Хамгийн түрүүнд аврах албаа сүүлийн үеийн автомашинтай болгох хэрэгтэй байна. Гал унтраах үндсэн албаны автомашиныхаа тоог нэмэх шаардлагатай байгаа. Хэдийгээр өнгөрсөн жил аймаг галын автомашин шинээр худалдаж авч өгсөн ч эдүгээ үйлчилгээнд ашиглагдаж буй машины ихэнх 30-40 жил ашиглагдсан байх жишээний. Тэгээд ч ОХУ-д үйлдвэрлэгдсэн машин болохоор сэлбэг хэрэгсэл нь жилээс жилд олдохоо больж байгаа. Орос үйлдвэрлэхээ больсон шүү дээ. Ашиглалтынх нь ч хугацаа дууссан. Тиймээс орчин үеийн өндөр хүчин чадалтай шинэ техникээр хангах шаардлага зүй ёсоор тавигдаж байна. Манай байгууллагын хувьд байр савыг нь урьдчилаад бэлдсэн. Дулаан гарааш бэлэн байна. Энэ жил манай аймагт

# ГАЗРЫН БҮТЭЦ ГУРАВДУГААР ЗЭРГИЙН АНГИ ГЭЖ ҮНЭЛЭГДДЭГ

мэргэжлийн ур чадвар, бие бялдрыг сайжруулах онцгой ач холбогдолтой.Тэмцээн хоёр жилд нэг удаа зохион байгуулагддаг. Энэ жилийн бүсийн аварга шалгаруулах тэмцээнийг аймагтаа зохион байгуулахаар бэлтгэлээ базаагаад байгаа. Зургаан аймгийн тамирчид ирж оролцоно. Манайх тамирчдаа бэлтгэлд гаргасан. Бидний хувьд бусдаас туршлага судлах, албан хаагчдаа туршлагажуулах онцгой ач холбогдолтойн дээр дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд оролцох тамирчдыг эндээс сонгон шалгаруулах юм.

**-Танай баг, хамт олны амжилтыг сонирхвол?**

-Энэхүү спортод байлдааны нөөцөөс шаардлагатай хөрөнгө, санхүүг гаргуулдаг. Засаг дарга бидний зовлон жаргалыг маш сайн ойлгодог нь сайн хэрэг. Он гарсаар орон нутагт зохион байгуулсан сургалтын зардлыг аймгийн Засаг дарга шийдэж өгсөн. Ер нь манай байгууллагын өдөр тутмын үйл ажиллагаа аймаг, орон нутагтайгаа нягт хамтран ажиллаж, харилцан ойлголцож чаддагийн үр дүнд өдий зэрэгтэй яваа гэж хэлж болно.

**-Та гал унтраагчаас газрын дарга хүртлээ бүхий л шат дамжлагад ажилласан дэд хурандаа. Тиймээс шинэ залуу боловсон хүчинд сэтгэлийн дэм өгөх, урмаар тэтгэх тал** бүхнийг шинэ, залуу боловсон хүчин хүндээр тусган авч шантрах нь бий. Тийм үед нь сэтгэл санааны дэмжлэг үзүүлж, сэтгэлийн хат суулгах ёстой. Нүд хальтрам зүйл дээр очсон алба хаагчид хэцүү байдалд орсон тухайгаа дараа нь ярьдаг. Сэтгэлзүйн зөвлөгөө өгөх үүрэг бүхий сэтгэлзүйч, эмч мэргэжилтнүүд манайд ажилладаг.

**-Орох айл үүднээсээ гэдэг. Танай байгууллагын өнгө төрх сайхан харагдаж байна шүү. Эдийн засаг хямарсан энэ үед шинээр барилга барьж, ашиглалтад оруулна гэдэг амаргүй ажил шүү?**

-Ажил амьдралынхаа гарааг даргаар ангидаа томилогдон ирж байлаа. Албан тушаалын хувьд багаас нь байгууллага удирдах хэмжээнд хүртлээ өссөн байна. Байгууллагаа өнгөтэй, өөдтэй авч явья гэсэн үүднээс газраа өөрийн гэсэн орон байртай болголоо. Өмнө нь манайх цагдаагийн газрын хашаан дотор үйл ажиллагаагаа явуулдаг байсан юм. Шинэ барилгатай болох зорилго тавьж, арав гаруй жил хөөцөлдөж байж сая нэг юм өөрийн гэх байр савтай болсон. Онцгой байдлын ерөнхий газар маань ч дэмжиж, Засгийн газар болон холбогдох байгууллуудад хандан хүсэлт гарган, албан бичиг явуулах зэргээр их тус болсон. Хамгийн хэцүү нь барилга барих ажилтан албан тушаалын шинэ орон сууцанд нүүж орсон. Одоо гурван хүний асуудлыг шийдэх хэрэгтэй байгаа. Миний, бидний дараагийн зорилго бол ажилчдын орон сууц барих явдал. Ангийн бие бүрэлдэхүүн байнга шинэчлэгдэж байдаг учраас шилжин ирэгсдийг албан тушаалын орон сууцаар хангах, нийгмийн асуудлыг шийдэх нь миний үүрэгт ажлын нэгээхэн хэсэг.

**-Таны болоод хамт олны тань цаашдын зорилго юу байна вэ?**

-Онцгой байдлынхаа газрыг өргөжүүлэх, хүчин чадлыг сайжруулах, нэмэгдүүлэх, ард иргэд рүү хандсан үйлчилгээг гамшгаас хамгаалах команд штабын сургуулилтыг есдүгээр сард сард зохион байгуулах юм. Бэлтгэл ажил хангагдаж байгаа. Гамшгаас хамгаалах чадавхийг бэхжүүлье. Дээр нь гамшгаас хамгаалах нөөцтэй болъё гэж төлөвлөөд шаардагдах төсөв хөрөнгөтэй холбоотой саналаа аймгийн Засаг дарга, ИТХ-д хүргүүлсэн. Үүнийг шийдэх аваас гамшиг осол болж эмнэлэг, хөдөө аж ахуйн албыг хээрийн нөхцөлд шилжүүллээ гэхэд хээрийн эмнэлгийн зориулалтаар ашиглаж болох майхан савны нөөцтэй болох юм.

**Танд болон танай хамт олонд ажлын амжилт хүсье.**




# З.ЭНХТӨР: АН-ЫНХАН ЯЛАГДЛАА ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРЧ ЧАДАХГҮЙ БАЙНА





СҮХБААТАР АЙМГИЙН ОНГОН СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ
22090 Хавирга Онгон сум
2017.03.31 № 13
СҮХБААТАР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГАД
Онгон сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын ээлжит бус дөрөвдүгээр хуралдаан 2017 оны 03 сарын 31-ний өдөр хуралдаж зохион байгуулалтын асуудлуудаа хэлэлцэн баталлаа.
Монгол улсын "Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль"-ийн 26 дугаар зүйлийн 26.[illegible], 26.5 дахь заалтуудыг үндэслэн сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлын [illegible] дөрөвдүгээр хуралдаанд оролцсон [illegible] хувийн санал авсан Очир[illegible] сумын засаг дарга[illegible] хүргүүлж байна.
ДАРГА [illegible]


МОНГОЛ УЛС СҮХБААТАР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА
22000 Баруун-Урт, Сүхбаатар аймаг
Утас, факс: 70512121, 70518232
2017.04.05 № 1/493
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАРТ
Онгон сумын Засаг даргад нэр дэвшсэн Очирбат овогтой Үнэнборын хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянуулахаар хүргүүлж байна.
Хавсралт....11....хуудастай.
З.ЭНХТӨР
000321

Сүхбаатар аймгийн АН-ын гишүүд аймгийнхаа төв талбайд цуглаан, суулт зохион байгуулаад 20 гаруй хонож байна. Энэхүү асуудалтай холбоотойгоор өнөөдөр МАН-ын Хууль эрх зүйн газрын дарга Р.Саруул, Сүхбаатар аймгийн Засаг дарга З.Энхтөр, Иргэдийн хурлын дарга Б.Гансүх, Иргэдийн хурлын тэргүүлэгч Ш.Мандахнар, МАН-ын Хууль эрхзүйн газрын дарга Р.Саруул нар хэвлэлийн бага хурал зарлаж, сэтгүүлчдэд үүсээд байгаа нөхцөл байдлын талаар бодит мэдээллийг өгсөн юм.

Монгол Улсын үндсэн хууль, Сонгуулийн тухай хуульд заасны дагуу аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгчдийг сонгох 2016 оны зургадугаар сарын 29-ний өдрийн ээлжит сонгуулиар Сүхбаатар аймгийн ИТХ-ын 33 суудлаас МАН 17, АН 16 суудлыг авч, МАН ялалт байгуулжээ. Ийнхүү хуулийн дагуу буюу долдугаар сарын 19-ний өдөр анхдугаар хуралдаанаа хуралдуулсан байна. Уг хуралд АН-аас сонгогдсон 16 иргэдийн төлөөлөгч тодорхой шалтгаан хэлэлгүйгээр суугаагүй учраас олонхи болсон МАН-ын 17 төлөөлөгч хурлаа зохион байгуулж, Иргэдийн хурлын даргыг томилох, Иргэдийн хурлын тэргүүлэгчдийг сонгох, Засаг даргаар томилуулах хүний нэрийг өргөн мэдүүлэх гэх хууль ёсны шийдвэрүүдийг гаргасан байна. Үүнийг үндэслэн Монгол Улсын Ерөнхий сайд Засаг даргыг батламжилжээ.

Энэ цагаас эхлэн Сүхбаатар аймгийн тулга тойрсон маргаан, учир утгагүй тэмцэл өнөөг хүртэл үргэлжилж, асуудлууд шүүх цагдаагийн шатанд яригдаж байгаа аж. Тодруулбал, АН-ын гишүүд Сүхбаатар аймгийн Дарьганга суманд МАН-аас нэр дэвшиж, ялалт байгуулсан Д.Болдбаатарыг Сонгуулийн тухай хуулийн 70.1.4 дэх хэсгийг зөрчсөн гэх 44 дугаартай шийтгэврийг 2016 оны 6-р сарын 30-ны өдөр Сүхбаатар аймаг дахь эрүү, иргэний хэргийн анхан шатны шүүхээс гаргуулсан байна. Энэхүү шүүхийн шийдвэр ямар ч үндэслэлгүй, АН-ын санаатай явуулга байсан гэж үзэн, Сүхбаатар аймгийн МАН-аас давж заалдах шатны шүүхэд гомдол гаргасныг 7 дугаар сарын 20-ны өдөр эцэслэн шийдвэрлэжээ.

Харин АН-аас МАН-ын 17 төлөөлөгч хурлаа зохион байгуулсан нь хууль бус гэх гомдлыг Захиргааны хэргийн шүүхэд гаргасан боловч дээд шүүхийн эцсийн шийдвэрээр 2016 оны 12 дугаар сарын 19-ний 444 дүгээр тогтоолоор дээрх гомдлыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгосон байна. Энэхүү тогтоолд Сүхбаатар аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын анхдугаар хуралдаан товлогдсон 2016 оны долдугаар сарын 19-ний өдөр нэр дэвшигч Д.Болдбаатарыг "нэрийн жагсаалтаас хассан" эрх бүхий байгууллага буюу Сонгуулийн хорооны шийдвэр гараагүй байсан бөгөөд Д.Болдбаатар нь төлөөлөгчийн бүрэн эрхээ хэрэгжүүлэн анхдугаар хуралдаанд оролцсон байна. Мөн "33 төлөөлөгчөөс 17 нь буюу олонхи хуралд ирсэн" гэж үзсэн нь Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 23.7-д заасныг зөрчөөгүй болно. Тиймээс анхдугаар хуралдааны бүхий л шийдвэр хүчин төгөлдөр хэмээн тодорхойлсон байгаа юм.

Маргаантай тойргийн хувьд дахин сонгууль явагдаж, АН-ын гишүүн П.Мөнхжаргал сонгогдсон гэх боловч тэрбээр Сонгуулийн тухай хуулийн хэд хэдэн заалтыг ноцтой зөрчсөн тухай болон хүчингүй болсон Иргэдийн хурлын тамга, албан бланк ашиглан хууль бусаар Сонгуулийн хороо байгуулж, хууль бус сонгууль явуулахаар оролдсон гэмт хэргийн шинжтэй үйлдэлд нь хуулийн байгууллагад шалгагдаж, хоёр шатны шүүхээр хэлэлцэгдэн, 2017 оны хоёр дугаар сарын 24-ны өдрийн 36 тоот магадлал, 2017 оны 3 дугаар сарын 9-ний өдрийн 44 тоот магадлалаар П.Мөнхжаргалыг Сүхбаатар аймгийн Цагдаагийн газарт дахин шалгуулахаар шилжүүлэн, шалгах ажиллагаа дуусаагүй, Прокурорын шатанд хянагдаж байгаа ажээ.

Ийнхүү маргаантай асуудлууд шүүхийн шатанд эцэслэн шийдвэрлэгдээгүй байхад Сүхбаатар аймгийн АН-ын удирдлагууд иргэдэд буруу, ташаа мэдээлэл түгээж, жагсаал цуглаан зохион байгуулаад зогсохгүй энэхүү жагсаалдаа бага насны хүүхдүүдийг ашиглаж байгаа нь тодорхой хууль тогтоомжуудыг зөрчиж байж болзошгүй бөгөөд хүүхдийн эрхийг хамгаалах зэрэг байгууллагууд тус асуудлыг анхааралдаа авч ажиллаж байгаа гэдэгт итгэлтэй байгаагаа хэвлэлийн бага хуралд оролцогчид мэдэгдсэн юм.

Хэвлэлийн хурлын үеэр Сүхбаатар аймгийн Засаг дарга З.Энхтөр "АН-ын гишүүдийн зүгээс бидэнд дөрвөн шаардлага тавьсан. Нэгдүгээрт, намайг гурван жил жил төрийн албанд ажиллаагүй байж Засаг дарга болсон. Тиймээс сайн дураараа огцор. Хоёрдугаарт, П.Мөнхжаргалын бүрэн эрхийг зөвшөөр. Гуравдугаарт, Онгон сумын Засаг даргыг томил. Дөрөвдүгээрт, Төрийн албан хаагчдыг халсан асуудалдаа уучлалт гуйж, буцаан ав гэсэн. П.Мөнхжаргалын хувьд эрүүгийн хоёр ч зүйл анги дээр шалгагдаж байгаа. Хэрэв шүүх, прокуророос түүний гэм буруугүйг тогтоочихвол бүрэн эрхийг нь хүлээн зөвшөөрөхөд асуудалгүй гэдгээ АН-ынханд өгчихсөн байгаа. Онгон сумын Засаг даргыг томилох тухайд энэ шаардлагаа гаргасныхаа маргааш нь буюу 3 дугаар сарын 31-нд томилуулах бичгээ ирүүлсэн. Бид холбогдох бичиг баримтыг нь орон нутгаасаа бүрдүүлээд АТГ-т шалгуулахаар өгсөн. Гэтэл өнөөг хүртэл АТГ-аас бидэнд хариулт өгөөгүй байна. Ямар нэгэн ашиг сонирхолын зөрчилтэй эсэхийг зайлшгүй АТГ-аар шалгуулж байж Засаг даргыг томилодог. Мөн төрийн албан хаагчдыг халж сольсон асуудал миний эрх мэдлээр хийгдсэн зүйл биш. Зарим алба, газрууд нийлсэнтэй холбоотойгоор цомхотголд өртсөн, Засаг даргын тамгын газрын бүтцийг Засгийн газрын 9 дүгээр тогтоолоор 37 байна гэж заасан дагуу 54 байсан орон тоог хуулийн дагуу цөөлсөн. Албан хаагчийг халж, сольсонтой холбоотой асуудал Захиргааны шүүхээр шийдэгдэх ёстой. Өлсгөлөн зарлана, жагсана, цуглана гэдгээр эдгээр асуудал шийдэгдэхгүй. Түүнчлэн "Сүхбаатар аймаг төсвөө баталж чадахгүй, цалин тавих чадамжгүй үйл ажиллагаа нь доголдсон байдалтай байна" гэх худал мэдээллийг нийгэмд тарааж байна. Манай аймаг үйл ажиллагаагаа хэвийн явуулж байгаа. Хэдийгээр МАН, АН-ын иргэдийн төлөөлөгчдийн суудал 16:16 байгаа боловч бид АН-ынхныг хуралдаа битгий суу гэж хэлсэн зүйл байхгүй. Харин ч эсрэгээрээ хуралдаа сууж, аймаг орон нутгийнхаа асуудлыг шийдвэрлэе. Ганц хүний эрх ашгийн төлөө бүгд ингэж туйлширч болохгүй гэж хэлж байгаа. Хамгийн гол нь найман жил орон нутгийн удирдлагыг барьсан АН-ынхан ялагдлаа л хүлээхгүй байгаагаас энэ бүгд үүдэлтэй" хэмээн ярилаа.

NO STRESS

ДУУЛГАХ СОНИН

Б.СУМЪЯА



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

# Баримтат гэрэл зургийн шилдэг бүтээлээс дэлгэлээ

Баримтат гэрэл зураг сонирхогч залуу зурагчдын шилдэг бүтээлийг олон нийтэд таниулах, дэмжих зорилготой "Шинэ бүтээл-хүмүүс-6" үзэсгэлэн өчигдөр Гамма галлерейд нээлтээ хийлээ. Үзэсгэлэнг баримтат гэрэл зургийн "Ц.Батзориг" сангаас санаачлан зургаа дахь удаагаа зохион байгуулж байгаа бөгөөд 80 гаруй зурагчны 700 орчим бүтээлээс шалгарсан шилдэг 40 зурагчны 47 бүтээлийг сонгон олон нийтэд танилцуулж байна.

"Ц.Батзориг" сангийн дэд тэргүүн Д.Давааням "Энэ жилийн үзэсгэлэн Ц.Батзориг агсны төрсөн өдөр тохиож буй гэдгээрээ онцлогтой. Бас мэргэжлийн шүүмжлэгч, фото редакторууд үзэсгэлэнд ирүүлсэн бүтээлийг шүүж, зураг бүрийн дор шүүмж бичдэгээрээ онцлогтой. Гэрэл зурагт өөрийн авсан зураг өөрт сайхан харагдах тохиолдол байдаг учраас өөр хүний нүдээр бүтээлээ шүүмжлүүлэх, сонголт хийлгэх хэрэгцээ шаардлага байдаг юм. Тэр үүднээс манай шүүмжлэгч, фото редакторууд зураг бүрт боломжоороо шүүмж бичсэн" гэлээ.

Баримтат гэрэл зурагчдын ур чадвар жилээс жилд сайжирч буйтай холбоотойгоор энэ удаагийн үзэсгэлэнд гарах шилдэг бүтээлийг шалгаруулахад хүндхэн байсныг ч үзэсгэлэнгийн нээлтийн үеэр шүүгч С.Туяа хэлж байлаа. Тэрбээр "Үзэсгэлэнд маш олон бүтээл ирсэн. Урьд нь шүүлтэд ирсэн зурагнуудаас зураг сонгох гэж зовдог байсан. Тэгвэл энэ жил хангалттай бүтээлүүдээс өөрсдийнхөө санхүүгийн хэмжээнд тохируулж, бүтээл сонгож авсан. Энэ ч бас яггүй даалгавар байдаг юм байна. Манай залуу зурагчид сайжирчээ. Жилээс жилд ур чадвар нь нэмэгдэж байгаад бид үнэхээр баяртай байгаа" гэсэн юм. "Ц.Батзориг" сан нь нэрт гэрэл зурагчин Ц.Батзориг агсны үйл хэргийг үргэлжлүүлэх, баримтат гэрэл зургийг хөгжүүлэх, гэрэл зургийн үнэлгээ, үнэлэмжийг дээшлүүлэхийн зэрэгцээ гэрэл зурагчдыг дэмжих, тэдний бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх, хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилгоор энэ удаагийн үзэсгэлэнг зохион байгуулжээ.

Гэрэл зурагчин Ц.Батзориг агсан 1998 онд бие даасан "Хүмүүс" гэрэл зургийн үзэсгэлэнгээ дэлгэж байсан бол хоёр дахь "Хүмүүс" үзэсгэлэнг 2013 онд гэрэл зурагчин Д.Давааням Ц.Батзориг агсны дурсгалд зориулж хамтарсан үзэсгэлэн хэлбэрээр гаргасан байдаг. Харин 2014 оноос эхлэн "Шинэ бүтээл-Хүмүүс" үзэсгэлэн болгон гэрэл зурагчдын дунд нээлттэйгээр зарлаж, шалгаруулалтад ирсэн нийт бүтээлээс тухайн жилийн "Шинэ бүтээл-Хүмүүс" үзэсгэлэнд гарах шилдэг бүтээлийг сонгон авдаг болсон байна. Үзэсгэлэн ирэх сарын 5 хүртэл үргэлжилнэ.



Бидэнд тохиолдсон хүндхэн хөгтэй явдлууд

**Solongo Bayarsaikhan**

Хүү аавтайгаа хамт жижигхэн гахайн ферм рүү яваад ирлээ. "Ээж ээж, би гахай харсан. Бас ямаа, ишиг, пони харсан" гээд л их сонинтой ирлээ. Би ч "Өөр юу юу харсан, сонирхолтой байсан уу" гэж асуутал "Ээж би гахайн мээм харсан. Гахай маш олон мээмтэй байсан шүү. Харин мээмнүүд нь таныхаас том юм байна билээ" гэж үү. Гахайнаас жижигхэн мээмтэй байхдаа яах вэ дээ. Сүүний чиглэлийн гахай байдаггүй биз дээ. Ха ха ха

Улаанбаатарт:

Маргааш
Өдөр 22
Шөнө 4

Нөгөөдөр
Өдөр 16
Шөнө 3

Өдрийн зурхай

**ХАВРЫН АДАГ ХӨХ ЛУУ САР ХОЁР ХАР МЭНГЭТЭЙ ХӨХ БИЧ ӨДӨР**

**Наран ургах шингэх:** 05.41-19.59

**Үс засуулбал:** Нас ахар болно



*Тухайн өдөр бар, туулай, бич, тахиа жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба үхэр, луу, хонь, нохой жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Буян үйл үйлдвээс өлзийтэй, өргөл хүндлэл, бурханд соёрхол тавих, амирлуулах, дэлгэрүүлэх, эрхшээх үйл нигууд бүтээх, ламд золгох зэрэг цагаан зүгийн үйлэнд сайн. Баруун нүд татвал холын сураг сонсох, зүүн нь татвал эд олдох, баруун чих хангинавал ундаа олдох, зүүн чих хангинавал түлэгдэх, нохой уливал үхсэний сураг сонсох, хэрээ дуугарвал нөхөртэй учрах, тагнай загатнавал хувцас олдох, бие татвал эцэг, эхэд муу. Хөл татвал хэрүүл, тэмцэл гарах муу ёр болой. үйл бүрүүтгах, ламд золгох зэрэг цагаан зүгийн үйлэнд сайн. Баруун нүд татвал холын сураг сонсох, зүүн нь татвал эд олдох, баруун чих хангинавал ундаа олдох, зүүн чих хангинавал түлэгдэх, нохой уливал үхсэний сураг сонсох, хэрээ дуугарвал нөхөртэй учрах, тагнай загатнавал хувцас олдох, бие татвал эцэг, эхэд муу. Хөл татвал хэрүүл, тэмцэл гарах муу ёр болой.*

ОДДЫН АМЬДРАЛ

## Жэй Ло шинэ найз залуугийнхаа талаар ам нээлээ

Дуучин, жүжигчин Женнифер Лопез мэргэжлийн бэйсболын тамирчин Алекс Родригизын талаар анх удаагаа ам нээжээ. Эдүгээ 47 настай дуучин бүсгүй өнгөрсөн сараас эхлэн Алекстай болзож, үе үехэн гэрэл зурагчдын дуранд өртөх болсон байдаг.Тэгвэл шинэхэн хувийн харьцааныхаа талаар тэрбээр Элений шоу нэвтрүүлэгт оролцох үедээ анх удаагаа ам нээсэн гэнэ. Бүсгүй "Лос-Анжелес хотод байрлах нэгэн ресторанд зоог барьж байхдаа Алекстай санаандгүй тааралдсан. Тэр үеэс л бидний харилцаа эхэлсэн. Яагаад ч юм түүний мөрийг цохиод "сайн уу" гэж хэлсэн. Харин тэр "хүүе Женнифер" гэж хариулсан" гэж ярьжээ. Алекс дуучин бүсгүйн утасны дугаарыг аль эртнээс мэддэг байсан учир тэр өдрөөс хойш холбоо барьж, оройн зоог хамтдаа барих болсон гэнэ. Жэй Ло өнгөрсөн жилийн наймдугаар сард удаан хугацаанд үерхсэн бүжигчин Каспер Смартаас салж, удалгүй реппер Дрэйктэй дотноссон ч, тэдний харилцаа удаан үргэлжлээгүй билээ.







